

Ерөнхий мэргэжлийн эмчийн мэргэжлээр эмчлэх зөвшөөрөл олгох шалгалтын жишиг сорил-6

Сорилын зөв хариулт

1-A, 2-E, 3-B, 4-A, 5-C, 6-E, 7-A, 8-B, 9-D, 10-C, 11-D, 12-C, 13-D, 14-A, 15-A, 16-A, 17-D, 18-B, 19-C, 20-C, 21-A, 22-B, 23-D, 24-A, 25-B, 26-E, 27-B, 28-B, 29-A, 30-C, 31-B, 32-C, 33-D, 34-B, 35-B, 36-A, 37-B, 38-B, 39-E, 40-A, 41-B, 42-B, 43-D, 44-D, 45-A, 46-C, 47-B, 48-E, 49-E, 50-C, 51-C, 52-A, 53-A, 54-A, 55-C, 56-D, 57-A, 58-C, 59-D, 60-D, 61-C, 62-B, 63-B, 64-B, 65-D, 66-E, 67-E, 68-D, 69-D, 70-D, 71-A, 72-C, 73-B, 74-D, 75-D, 76-C, 77-C, 78-B, 79-A, 80-C, 81-B, 82-B, 83-A, 84-E, 85-C, 86-D, 87-B, 88-B, 89-B, 90-A, 91-A, 92-C, 93-B, 94-B, 95-E, 96-A, 97-D, 98-D, 99-C, 100-B, 101-B, 102-B, 103-B, 104-D, 105-B, 106-C, 107-C, 108-A, 109-C, 110-C, 111-C, 112-C, 113-B, 114-A, 115-C, 116-A, 117-B, 118-B, 119-E, 120-A, 121-C, 122-D, 123-B, 124-C, 125-B, 126-C, 127-A, 128-B, 129-D, 130-C, 131-C, 132-C, 133-A, 134-B, 135-E, 136-B, 137-A, 138-C, 139-D, 140-C, 141-A, 142-C, 143-A, 144-D, 145-D, 146-C, 147-E, 148-B, 149-C, 150-D, 151-C, 152-D, 153-A, 154-E, 155-A, 156-A, 157-E, 158-A, 159-E, 160-B, 161-A, 162-A, 163-A, 164-C, 165-C, 166-C, 167-C, 168-A, 169-D, 170-B, 171-C, 172-A, 173-E, 174-A, 175-C, 176-B, 177-A, 178-C, 179-A, 180-A, 181-A, 182-D, 183-C, 184-A, 185-C, 186-A, 187-A, 188-E, 189-A, 190-E, 191-D, 192-C, 193-E, 194-A, 195-E, 196-E, 197-E, 198-C, 199-C, 200-A, 201-E, 202-A, 203-C, 204-C, 205-C, 206-A, 207-A, 208-C, 209-A, 210-C, 211-A, 212-A, 213-A, 214-A, 215-E, 216-A, 217-A, 218-A, 219-A, 220-C, 221-D, 222-A, 223-A, 224-C, 225-A, 226-A, 227-A, 228-C, 229-C, 230-C, 231-C, 232-A, 233-C, 234-E, 235-A, 236-A, 237-A, 238-D, 239-E, 240-A, 241-D, 242-E, 243-A, 244-A, 245-A, 246-A, 247-A, 248-A, 249-A, 250-C, 251-C, 252-A, 253-C, 254-A, 255-A, 256-A, 257-A, 258-C, 259-A, 260-C, 261-C, 262-B, 263-E, 264-C, 265-C, 266-A, 267-E, 268-A, 269-C, 270-C, 271-C, 272-E, 273-A, 274-A, 275-E, 276-C, 277-D, 278-C, 279-A, 280-C, 281-C, 282-A, 283-C, 284-E, 285-A, 286-C, 287-A, 288-C, 289-A, 290-A, 291-C, 292-C, 293-A, 294-E, 295-A, 296-A, 297-A, 298-E, 299-A, 300-C, 301-E, 302-E, 303-E, 304-E, 305-C, 306-A, 307-C, 308-A, 309-E, 310-D, 311-C, 312-C, 313-C, 314-B, 315-E, 316-E, 317-E, 318-E, 319-E, 320-E, 321-C, 322-E, 323-E, 324-A, 325-A, 326-A, 327-A, 328-E, 329-E, 330-E, 331-C, 332-D, 333-C, 334-A, 335-E, 336-A, 337-A, 338-A, 339-A, 340-E, 341-E, 342-C, 343-E, 344-A, 345-E, 346-C, 347-E, 348-E, 349-A, 350-E, 351-E, 352-A, 353-A, 354-D, 355-B, 356-A, 357-E, 358-D, 359-C, 360-E, 361-A, 362-C, 363-C, 364-E, 365-E, 366-C, 367-E, 368-A, 369-D, 370-E, 371-D, 372-D, 373-A, 374-E, 375-E, 376-E, 377-A, 378-A, 379-E, 380-A, 381-C, 382-A, 383-E, 384-A, 385-A, 386-E, 387-A, 388-A, 389-E, 390-A, 391-A, 392-E, 393-C, 394-B, 395-A, 396-A, 397-C, 398-A, 399-B, 400-A, 401-E, 402-D, 403-A, 404-C, 405-C, 406-C, 407-A, 408-C, 409-A, 410-D, 411-C, 412-B, 413-A, 414-D, 415-A, 416-A, 417-E, 418-A, 419-D, 420-B, 421-E, 422-E, 423-B, 424-A, 425-C, 426-E, 427-D, 428-D, 429-A, 430-D, 431-A, 432-D, 433-C, 434-E, 435-E, 436-E, 437-D, 438-A, 439-D, 440-B, 441-D, 442-B, 443-C, 444-D, 445-A, 446-D, 447-D, 448-A, 449-C, 450-E, 451-B, 452-B, 453-C, 454-B, 455-A, 456-B, 457-A, 458-B, 459-D, 460-B, 461-E, 462-C, 463-D, 464-A, 465-C, 466-C, 467-B, 468-A, 469-A, 470-C, 471-C, 472-E, 473-B, 474-A, 475-A, 476-E, 477-C, 478-C, 479-D, 480-B, 481-E, 482-C, 483-C, 484-D, 485-B, 486-D, 487-A, 488-A, 489-A, 490-A, 491-B, 492-D, 493-B, 494-D, 495-B, 496-E, 497-A, 498-A, 499-A, 500-B, 501-B, 502-C, 503-A, 504-C, 505-D, 506-B, 507-C, 508-D, 509-B, 510-A, 511-A, 512-A, 513-C, 514-C, 515-A, 516-A, 517-B, 518-C, 519-E, 520-A, 521-A, 522-B, 523-A, 524-A, 525-A, 526-C, 527-A, 528-A, 529-C, 530-D, 531-B, 532-C, 533-D, 534-C, 535-A, 536-B, 537-C, 538-B, 539-C, 540-A, 541-B, 542-A, 543-A, 544-B, 545-E, 546-A, 547-E,

1. Нэг сонголттой тест (Зөвхөн 1 хариулт зөв байх) Энэ хэлбэрийн сорил нь А, В, С, D, E гэсэн дугаартай бөгөөд Зөвхөн 1 зөв хариуг сонгоно.
2. Олон сонголттой тест (Хэдэн ч хариулт зөв байж болох)
 - 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол (А.)
 - 1 ба, 3 дугаар хариултууд зөв бол (В.)
 - 2 ба 4 дугаар хариултууд зөв бол (С.)
 - Зөвхөн 4-р хариулт зөв бол (D.)

Бүх хариулт зөв бол (E.)

3. Шалтгаан хамаарлын тест (Заагдсан тестүүдийн үнэн зөв хийгээд тэдгээрийн шалтгаан хамаарлыг тодорхойлно.)

Зөв, Зөв, Зөв (A.)

Зөв, Зөв, Буруу (B.)

Зөв, Буруу, Буруу (C.)

Буруу, Зөв, Буруу (D.)

Буруу, Буруу, Буруу (E.)

/1./ Том үений ил гэмтлийн аюултай хүндрэл

A. Үений идээт үрэвсэл

B. Хийн эмболи

C. Цусан халдвар

D. Үе хөдөлгөөнгүй болох /анкилоза/

E. Нугалах, тэнийх байрлалд үений хөдөлгөөний хомсдол болох

/2./ Агтаал ясны чөмөгт гандан хэсгийн хугарлын гол эмчилгээ аль нь вэ?

A. Шахаж сунгах аппарат

B. Ясны чөмөгний голоор хадах мэс засал

C. Хугарлыг эвлүүлж гаднаас нь металл ялтасаар бэхлэх

D. Бариа засал, гөлтгөнөн боолт

E. Эвийн эмчилгээ

/3./ Шаант чөмөг, тахилзуур ясны хоорондох таславч (membrane) үндсэн үйл ажиллагаа аль нь вэ?

A. Шаант чөмөг тахилзуурын доод түвшинд зай (diastasis) гарахаас урьдчилан сэргийлнэ.

B. Тахилзуурт ачаалал өгөхөд аргаш бөхийхөөс урьдчилан сэргийлнэ

C. Тахилзуурын бүлэг булчингууд холбоотойгоор ажиллахад хангалттай зай бариулна.

D. Тахилзуур болон арын өнгөц хайрцагуудыг (compartments) салгаснаар цусгүйдлийн хам шинжийг хязгаарлах ач холбогдолтой

E. Шаантны доод төгсгөлийн 1/3-ийн цусан хангамжийг хэвийн явуулна

/4./ Дунд чөмөгний хүзүү хугарсан үед хийх үндсэн эмчилгээг нэрлэ.

A. Мэс засал

B. Ясны татлага

C. Гөлтгөнө боолт

D. Бариа засал

E. Зөөлөн татлага

/5./ Гол тэжээгч тараагуур судасны гэмтсэн үеийн эрт үеийн сонгомол шинжүүд:

A. Судасны түвшинд шарх үүссэн байх биеийн температур өгсөх, цус алдах, цусны цагаа бөөм ихсэх, гэмтсэн хэсэгт хавдах, гэмтсэн хэсгийн захад цус багадалт.

B. Судасны түвшинд шарх үүссэн цус алдалт, гэмтсэн хэсэгт хавдсан, захын хэсэгт цус багадалт илрэх

C. Шарх үүссэн, цус алдах, судасны шуугиан

D. Биеийн температур ихсэх, шарх үүссэн, цагаан бөөм олшрох, цус алдах

E. Гэмтсэн хэсэгт хавдах, шархтай захын хэсэгт цус багадах, судасны шуугиан гарах.

/6./ Тархины дарагдлын Саруул үе гэмтэл авснаас хойш хэдий хугацаанд үргэлжлэх вэ?

A. 30-40 минут

B. 1 цагаас 1 цаг 30 мин

C. 3-4 цаг

D. 6-8 цаг

E. 24-48 цаг

/7./ Түлэнхийн шархыг хэдэн зэрэг болгож хуваадаг вэ?

A. I, II, III-A, III-B, IV

B. I, II

C. I-A, II-B

D. I, II, III, IV-A, IV-B, V

E. I, II, III-A, III-B

/8./ Яс мөгөөрсний эмгэг /Остеохондропати/ ямар хүйсэнд илүү тохиолдох вэ?

- A. Эмэгтэй
 - B. Эрэгтэй
 - C. Хоёуланд нь адилхан
 - D. Хүндрэлтэй төрсөн тохиолдолд
 - E. Хагас дутуу хөгжилтэй
- /9./ Төрөлхийн майга тавхайн шалтгаан хүчин зүйл
- A. Үр хөврөлийн гажиг
 - B. Хэвлийд байхдаа гэмтэл авах
 - C. Төрөхдөө гэмтэх
 - D. Дисплазия
 - E. Хэвлий полимиелитээр өвдөх
- /10./ Атгаал чөмөгний дээд хэсгийн хугарал ангилал аль нь вэ?
- A. Фрикмани-ний ангилал
 - B. Maso-ний ангилал
 - C. Nee-гийн ангилал
 - D. London-ийн ангилал
 - E. Hawkins-ийн ангилал
- /11./ Бүрхэвчийн дунд артери хаанаас гардаг вэ?
- A. Гүрээний дотор артериас
 - B. Нурууны артериас
 - C. Гүрээний гадна артериас
 - D. Дээд эрүүний артериас
 - E. Доод эрүүний артериас
- /12./ Шаант, тахилзуурын синдесмозын гэмтлийн дараа яах вэ?
- A. Дотор хавчаарын хугарал хам тохиолдох
 - B. Шагай хам мултрана
 - C. Синдесмоз салалтыг зөв биш засаж, бэхэлсэн бол
 - D. Тахилзуур яс олон хугарах
 - E. Засахаас өмнө синдесмозын зай 1.5 см-аас их болно
- /13./ Тахилзуур ясыг шилжүүлэн суулгасны дараа гарах хүндрэл аль нь вэ?
- A. Явгаар явахад бэрхшээл гарна
 - B. Мэдрэлжилт (Dysaesthesia) алдагдана
 - C. Шагайгаар тогтворгүй юм шиг мэдрэмж төрнө
 - D. m.Flexor hallucis longus нугалах байрлалд хомсдол өгнө
 - E. Шагайн нугалах хөдөлгөөн хязгаарлагдана
- /14./ Дээд мөчний мэдрэл
- A. N.Axillaris-мөрний арын мултралын үед илүү тохиолдоно
 - B. Гэмтлийн үед судасны гэмтэл нь мөрний мэдрэлийн сүлжээг /Plexus brachialis/ бодвол элбэг тохиолдоно.
 - C. N.Radialis нь шууны 2 ясны хугарлын үед илүү гэмтэнэ
 - D. Атгаал ясны доод хэсэгт ил аргаар остеосинтез хийх үед N.Ulnaris-ыг хамгаалсан байх ёсгүй
 - E. Шуу ясны доод хэсгийн хугарлын үед N.Medianus гэмтэх нь ховор
- /15./ Гэмтсэн үед дархлаатай холбоотой шингэн (cytokines) аль эсээс ялгардаг вэ?
- A. Эсийн эндотелээс
 - B. Эритроцитээс
 - C. Зүрхний булчингаас
 - D. Уушигны альвеолын цэврүүнээс
 - E. Булчин эсийн судлаас (Striated)
- /16./ Түнхний үений гаж хөгжил /дисплазия/ хэдийгээс эмчлэх вэ?
- A. Төрснөөс эхлэн
 - B. 1 сар
 - C. 1-2 сар
 - D. 3 сар түүнээс дээш
 - E. 6 сартайгаа
- /17./ Олон хавирганы хугарлын үед хийх хэсгийн өвчин намдаагч бэлдмэлээр хориг хийх

- A. Хугарлын үзүүрүүдийн хооронд
- B. Паранефральный
- C. Школьниковын хориг
- D. Хугарсан хавирганы мэдрэлийн ёзоорт
- E. Цээжний ханыг мэдээгүйжүүлэх хориг

/18./ Олон жил өвдсөн 50 настай эрэгтэй хүний зүүн гарын урдуур овгор хавдартай, рентген зургаас атгаал яс нь хэлбэр дүрсээ алдсан нь биологийн, эсвэл механик аль хүч үйлчлэсний үр дагавар вэ?

- A. Механик хүчний шугам дагуу яс үүссэн
- B. Олон удаа стресс хугарал үүсч, өнцөг үүсч бороолсон
- C. Олон удаа гэмтсэнээс дасч томорсон
- D. Атгаал ясны уян хатнаас үүссэн хэлбэр алдалт
- E. Атгаал ясанд ирэх механик хүч суларснаас явагдсан шинэ эд эс ургах үзэгдэл

/19./ Мальгены хугарал гэж юу вэ?

- A. 2 талын умдаг суудал яс хоёулаа хугарах
- B. 2 талын суудал яс хугарч арын хана босоо байрлалаар хугарах
- C. Нэг талдаа умдаг суудал яс, ар талдаа ташаан дэлбээ босоо байрлалаар хугарах
- D. 2 талдаа умдаг суудал яс хугараад олон яс уулзахаар салах
- E. Ахар сүүл хугарч, ээрцэг салах

/20./ Майга тавхайд хэдэн настайгаас мэс заслын эмчилгээ эхлэх вэ?

- A. 6 сар
- B. 12 сар
- C. 1 нас
- D. 5 нас
- E. 7-10 нас

/21./ Бүсэлхий мэдрэлийн сүлжээ ямар мэдрэлээс хэлбэржих вэ?

- A. Th12-L4
- B. Th12-L5
- C. L1-L4
- D. L1-L5
- E. Th9-10

/22./ Ясны ил хугарлын үед газар дээр нь үзүүлэх анхны тусламжийг дурьдана

- A. Ясны татлага хийх
- B. Шарханд ариун боолт хийж, хугарлыг зөв байрлалд хөдөлгөөнгүй бэхлэх
- C. Шахаж сунгах аппарат тавих
- D. Битүү гөлтгөнө боолт тавих
- E. Яаралтай мэс засал хийж хугарлыг эвлүүлэх

/23./ Роландын хугарал ямар ясан дээр үүсэх вэ?

- A. Атгаал яс
- B. богтос яс
- C. шуу яс
- D. сарвуу яс
- E. шилбэ яс

/24./ Цахилгаан гүйдлийн хэсгийн шинж тэмдэг

A. Арьсанд модлог хэлбэрийн салаалалсан улаан судал арьсанд илэрнэ, дарахад алга болно

- B. Дээрхи шинж тэмдэг дарахад алга болохгүй
- C. Гүйдлийн тэмдэг үүснэ
- D. Эд хатуурч /металлизация болно/
- E. Цахилгаан гүйдлийн үйлчлэсэн хэсэгт нүүрсжилт болно

/25./ Үений ил гэмтлийн итгэлтэй шинж тэмдгийг нэрлэнэ үү?

- A. Үений түвшинд гүнзгий шархдах
- B. Шархнаас үений шингэн гарах
- C. Тэмтрэхэд үений шархны хэсэгт шаржигнах чимээтэй
- D. Үений хэсгийн шархнаас цус урсаж гарна
- E. Шархтай үений хөдөлгөөн эрс хязгаарлагдах

/26./ Булчингийн бүрэн болон хэсэгчилсэн тасралтыг ялгах үндсэн шинж нь

- A. Өвдөлтийн хам шинжийн илрэлээр
- B. Мөчний үйл ажиллагаа буурна
- C. Ихээхэн хавантай
- D. Янз бүрийн хэмжээтэй цус хурах, цус нэвчих
- E. Булчингийн тонус ихсэх

/27./ Тохойн үе хэдэн үелэмжээс бүтэх вэ?

- A. Хоёр үелэмж
- B. Гурван үелэмж
- C. Дөрвөн үелэмж
- D. Таван үелэмж
- E. Нэг үелэмж

/28./ Чихрийн шижин өвчтэй хүний яс хугарсны дараа бороололттой холбоотой доорхи асуултын аль нь буруу вэ?

A. Ясны эдгэрэлт эрт үед эсийн үржихэд тромбоцитын дутагдал нөлөөлдөг бороололт сул байна

- B. Яс хугарсны дараа гликемийн хяналт бороололтод нөлөөлөхгүй
- C. Диабит өвчин ясны эдгэрэлтийг удаашруулна
- D. Бороолохгүй бороололт удаашрах илүүтэй тохиолдоно
- E. Эрүүл хүнийхээс 2 дахин удаан эдгэрнэ

/29./ Хавирганы хугарлын хавхлага амьсгал авах үед хаашаа хөдлөх вэ?

- A. Дотогшоо
- B. Гадагшаа
- C. Хөдлөхгүй
- D. Урагшаа
- E. Хойшоо

/30./ Хиймэл үеийг тавихдаа хэрэглэх ясны цемент антибиотик 2-ыг холихдоо ямар арга хэрэглэх вэ?

- A. 5.0 антибиотик бэлдмэлд 40.0 цемент хийнэ
- B. Альбуминтэй антибиотик хийнэ
- C. Цефроксимин (cefroxime) нунтаг холино
- D. Шингэн антибиотик
- E. Лиофилный ванкомицин нэмнэ

/31./ Майга тавхайд эвийн эмчилгээг хэдэн нас хүртэл хийх вэ?

- A. 6 сар хүртэл
- B. 1 нас хүртэл
- C. 2.5-3 нас хүртэл
- D. 5 нас хүртэл
- E. Майгын элементүүдийг засартал

/32./ Дюшено-Эрба-ийн саажилтанд гарыг хамгийн тохиромжтой байлгах

- A. Дезо боолт
- B. Их бие дагуу гартай хам боолт
- C. Гадагш эргэлттэй мөрний үеэр суга $90\pm$ тэнэгэр өргөсөн байрлалд
- D. Байрлалын боолт хэрэггүй
- E. Нуруунд хүртэл гэдрэг байрлалтай боолт хийнэ

/33./ Смитын хугарал ямар ясан дээр үүсэх вэ?

- A. дунд чөмөг
- B. атгаал яс
- C. богтос яс
- D. шуу яс
- E. шилбэ яс

/34./ Хатуу хальсны дээрхи цусан хураа гэж юу вэ?

A. Гавлын ясны цөмөрсөн хугарал, тархины бяцралын голомт хатуу бүрхэвчийн доорхи шингэн хуралт нөхцөлдөн үүсдэг

B. Тархины хатуу бүрхэвчийн дунд артерийн гэмтэл, гавлын ясны венийн судасны гэмтэлээс үүдэн гавлын ясны дотор хана хатуу бүрхэвч хоёрын завсарт цус хурахын хэлнэ.

С. Тархины бүрхэвчийн венийн судас, вений синус гэмтсэнтэй холбоотойгоор хатуу ба зөөлөн бүрхэвч тархины эдийн завсар цус хурахыг хэлнэ.

D. Механик болон гадны хүчин зүйлийн нөлөөгөөр тархины бүтцийн голомтод болон голомтод бус өөрчлөлт гарахыг хэлнэ.

Е. Гэмтлийн улмаас үүссэн уураг тархины тусгалын ба амьсгал зүрх судасны төвийн үйл ажиллагааны түр зуурын саатлын шинжүүд илрэхийг хэлнэ

/35./ Хүүхдэд хатуу хальсны дор дал хугарахад тохиромжтой эмчилгээ аль вэ?

A. Ил засал + Дезо болт

B. Дезо боолт

C. Битүү засах + Дезо боолт

D. Хурсан цусыг соруулж аваад боолт хийх

E. Эмчилгээ шаардлагагүй

/36./ Гуяны өргөн хальсны булжилт /щелкающее бедра/ гол эмчилгээ аль нь вэ?

A. Мэс азсал

B. 1-2 жил ажиглана

C. Сэргээн засах эмчилгээг идэвхитэй хийнэ

D. Дулааны эмчилгээг өсвөр насны хүүхдэд хийнэ

E. Үрэвслийн эсрэг эмчилгээ

/37./ Түнхний мултралын мэс заслын эмчилгээний дараа бүрэн гишгэж явах хугацаа

A. 1 сарын дараа

B. 2 сарын дараа

C. 3 сарын дараа

D. Хагас жилийн дараа

E. Жилийн дараа

/38./ Мөрний мултралын үед илрэх шинж тэмдгийг дурьдана уу.

A. Эмгэг хөдөлгөөн

B. Пүрштэй юм шиг эсэргүүцэлтэй

C. Ясны хавиралдах чимээ мэдрэгдэнэ

D. Булчин хатингаршина.

E. Ясны хугарлын үзүүр ил гарна

/39./ Илизаровын аппаратыг шаант чөмөгний дээд хэсгийн хугаралд тавихдаа үений үрэвслээс хамгаалж үений шугамаас хамгийн багаар хир зайнд байрлуулах вэ?

A. Шаант чөмөгний толгойн доод хэсэгт

B. Тойгны шөрмөсний эхлэх хэсгийн төгсгөлөөр оруулна

C. 5 мм

D. 10 мм

E. 15 мм

/40./ Өвдөгний үеийг бүтнээр сольсон үед ямар хүндрэл өгдөг вэ?

A. 4-н толгойт булчингийн шөрмөс тойгны төгсгөлийн дээд хэсэгт фиброз, зангилаа үүснэ (Patellar Clink Syndrom)

B. Тойгны шөрмөс урагдах

C. Протезийн гадна тойгны хугарал үүсэх

D. 4-н толгойт булчингийн шөрмөс урагдаж, хагарна

E. Байнга дахисан амартрез үүснэ

/41./ Гилжгий хүзүүний ямар хэлбэр илүү тохиолдох вэ?

A. Ясны

B. Булчингийн

C. Рефлекторийн

D. Үрэвслийн

E. Зөөлөн эдийн

/42./ Дунд чөмөгний хүзүүний гэмтэл

A. Дунд чөмөгний хүзүү зөрүүтэй хугаралд хагас ил аргаар мэс засал хийх нь хагалгааны хугацаа богино бол өвчтөнд тохиромжтой

B. Хагалгаанд чиглүүлэх шөргүүд тавих үе нь тийм ч, чухал биш

C. 70- аас дээш насанд цемент бүхий түнхний хиймэл үе тохиромжтой

D. Дунд чөмөгний төвгөр дайрсан хугарлыг эвийн аргаар эмчлэх нь илүү үр дүнтэй

Е. С31, В22 хүзүүний дундуур хугарал

- /43./ Сормиентийн чигийг хугарлыг эвлүүлснээс хойш аль чөмөгт ясанд 3 долоо хоногийн дараа тавих вэ
- А. Дунд чөмөгний гандан хэсэг
 - В. Шуу чөмөгний гандан хэсэг
 - С. Шаант чөмөгний гандан хэсэг
 - D. Атгаал чөмөгний гандан хэсэг
 - Е. Богт чөмөгний гандан хэсэг
- /44./ Хөлдөлтийн хүндрэл хожуу
- А. Селсис
 - В. Остеомиэлит
 - С. Лимфаденит
 - D. Артрит
 - Е. Флегмона
- /45./ Хүүхдэд далны хугарал ямар механизмаар үүсгэгдэх вэ?
- А. Шууд механизмаар цохигдох
 - В. Гараа алдалж унах
 - С. Гараа хавчин унах
 - D. Мөрний үеэр эргэх хэлбэрээр цохигдох
 - Е. Нуруугаар бөхийн унахад
- /46./ Анхдагч-хойшлогдсон оёдлын хугацааг заана уу?
- А. Гэмтсэнээс хойш 1 долоо хоногийн дараа шарханд цэгцэлгээ хийж оёдол тавих
 - В. Гэмтсэнээс хойш нэг сарын турш шархыг цэвэрлэж дараа нь оёдол тавих
 - С. Шарханд урьдчилан цэгцэлгээ хийгээд мөхлөг үүсэхийн өмнө 5-6 хоногийн дараа оёдол тавих
 - D. Шарханд мөхлөг /грануляция/ үүсгээд зах, ирмэг нь хөдөлгөөнтэй, бэхжээгүй үед сорвигүй нөхцөлд оёдол тавих
 - Е. Мөхлөг зах, ирмэг бэхжиж сорвижсон үед өөлж аваад оёдол тавина
- /47./ Төрөлхийн тойгны мултралд мэс засал хийх тохиромжтой нас
- А. 3 нас
 - В. 5 нас
 - С. 7 нас
 - D. 10 наснаас доош
 - Е. 15 насанд
- /48./ Арьсан дор булчингийн гэмтэл үүсэх тэргүүлэх шалтгаан нь:
- А. Шууд механизм
 - В. Бичил гэмтлээр
 - С. Гэнэт булчин агшилтын тэнцвэржилт алдагдсанаас
 - D. Булчин шөрмөсний эмгэг байдлын нөлөөнөөс
 - Е. Шууд биш механизмаар
- /49./ Шаант чөмөгний дээд төгсгөлийн anteromedial (урд, дотор) талын шахагдсан хугарал ямар гэмтэлтэй хавсардаг вэ?
- А. Дотор талын мениск урагдах
 - В. Гадна мениск урагдах
 - С. Урд талын чагтан холбоос (ACL) урагдах
 - D. Ар талын чагтан холбоос (PCL) урагдах
 - Е. Ар, хажуугийн өнцгийн (corner) гэмтэх
- /50./ Шууны мэдрэл мөрний сүлжээний аль багцаас гарах вэ?
- А. Хажуу
 - В. Дотор
 - С. Ар
 - D. Ар болон хажуу
 - Е. Хажуу болон ар
- /51./ Тромбо-эмболийн эрсдэлтэй өвчтөнд уг хүндрэлээс урьдчилан сэргийлэхэд аль заалт нь тохиромж муутай вэ?
- А. Энэ эмчилгээг хэрэглэсэн үед хүндрэл гарахгүй нөхцөлд хэрэгжүүлнэ.

- В. Цус алдалтын эрсдэл багассан эхний 2 хоногийн дараа хэрэглэнэ.
С. Тромбо үүсэх боломжтой тэр үед эхэлнэ.
D. Эмнэл зүйн хувьд эрсдэлийг өнгөртөл эмчилгээг үргэлжлүүлнэ
E. Өвчтөний биеийн байдлыг харгалзана
- /52./ Парадоксаль амьсгалын үед уушги хоорондын хийн солилцоо амьсгал авах үед хаашаа шилжих вэ?
A. Эрүүл уушигнаас эмгэг уушиг руу
B. Эмгэг уушигнаас эрүүл уушиг руу
C. Баруунаас зүүн тийш
D. Зүүнээс баруун тийш
E. Гаднаас дотогш
- /53./ Остеонекрозоор хүндрэх дараах нөхцлүүдээс аль нь нөлөөлдөг вэ?
A. Архийг хэтрүүлэн хэрэглэх
B. Халдвар
C. Pethes-ын өвчин
D. Жирэмсэн
E. Дунд чөмөгний дээд хэсгийн эпифизийн гулсалт
- /54./ Майга тавхайд хэдэн сартайгаас эвийн эмчилгээ хийж эхлэх вэ?
A. Төрснөөс
B. 1 сарын дараа /төрснөөс/
C. 3 сарын дараа /төрснөөс/
D. Хагас жилийн дараа /төрснөөс/
E. 1 нас
- /55./ Ключке-ийн саагийн үед ямар шинж давамгайлах вэ?
A. Сарвуу, хуруунууд хөдөлгөөнгүй
B. Хуруунууд хөдөлгөөнтэй мөрний үеэр хавчин, дотогш эргэсэн байдалтай
C. Мөрний үеэр хөдөлгөөнтэй, сарвуу хуруунууд хөдөлгөөнгүй
D. Мөч бүхэлдээ хөдөлгөөнгүй /төвийн гаралтай/
E. Гемипарез
- /56./ Колессын хугарал ямар ясан дээр үүсэх вэ?
A. Шилбэ яс
B. атгаал яс
C. богтос яс
D. шуу яс
E. дунд чөмөг
- /57./ Гавал тархины гэмтлийг Глазгогийн шаталбараар хэдэн оноотой байвал тархи үхжсэн гэж үзэх вэ?
A. 3 балл
B. 4 балл
C. 5 балл
D. 7-8 балл
E. 9-10 балл
- /58./ Түнхний төрөлхийн мултралын үед рентгенд гарах шинжийг заа
A. Гюнтерын шугам өөрчлөгдөх
B. Маркс шинж
C. Путти шинж
D. Хильгенрейнерийн шинж
E. Розер-Нелотаны шугам өөрчлөгдөх
- /59./ Атгаал ясны хугарлын үед ямар мэдрэл ихэвчлэн гэмтдэг вэ?
A. N. ulnaris
B. N. brachialis
C. N. medianis
D. N. radialis
E. N. cutenius
- /60./ Хүний түнхний үе хөгжлийн ямар үедээ хамгийн тогтворгүй байх вэ?
A. Ургийн 8-н 7 хоногт teres холбоо үүсэхээс өмнө

- В. Ураг 22 - 7 хоногт tefes холбоо судасжина, үүнээс өмнө
 - С. Жирэмсний сүүлчийн 3 сард
 - Д. Төрөх үедээ
 - Е. Төрсний дараа 12-оос 36-н сард
- /61./ Өвдөгний үеийг сольсноос хойш 12 сарын дараа өвдөх гол шалтгаан нь юу вэ?
- А. Халдвар
 - В. Тойг хугарах
 - С. Тохируулга (Malaligament) буруу хийснээс
 - Д. Диабет
 - Е. Хагалгаанд орох үедээ байнгын сэтгэл санааны доройтол, тайван бус байсан
- /62./ Аарцаг ясны хугарал Школьниково-Саливановын аргаар аарцагны доторхи хоригийг аль цэгээс хатгалт хийх вэ?
- А. Сүүжний дэлбээний ясны урд төвгөрөөс 5 см дээрээс
 - В. Сүүжний дэлбээний ясны урд төвгөрөөс 1 см дотогш
 - С. Сүүжний дэлбээний ясны урд төвгөрөөс 1 см дотогш 3 см-ийн доор
 - Д. Сүүжний дэлбээний ясны урд төвгөрөөс 0.5 см дотогш
 - Е. Сүүжний дэлбээний араас
- /63./ Майга тавхайд илүү нөлөөлөх булчин аль нь вэ?
- А. Хуруунуудын урт нугалагч
 - В. m.tibialis anterior
 - С. Боривны шөрмөс
 - Д. m.peroneus саажна
 - Е. m.tibialis posterior
- /64./ Гэмтлийн шокын патморфологийн үзүүлэлт
- А. Цусны эргэлтийн эзлэхүүн багасна
 - В. Элэг, дэлүү, чацархайн судсуудад цус хуримтлагдана
 - С. Булчингийн хялгасан судсанд цус хурна
 - Д. Булчингийн сувганцруудад лимф хурна
 - Е. Мембраны нэвчимхий чанар ихэснэ
- /65./ Беннетын хугарал ямар ясан дээр үүсдэг вэ?
- А. шилбэний яс
 - В. атгаал яс
 - С. шуу, богтосны яс
 - Д. сарвууны яс
 - Е. дунд чөмөг
- /66./ Оо дээш температурт нөлөөлөх хүчин зүйл
- А. Салхитай цаг агаар
 - В. Чийглэг
 - С. Барьсан хувцастай
 - Д. Судасны архаг өвчлөл, гэмтэлтэй
 - Е. Эцэж ядарсан, шархдсан
- /67./ Төрөх үед хүүхдийн эгэм хугарахад ямар шинж илрэх вэ?
- А. Мөрний үенд цус хурна
 - В. Хугархайд шаржигнах чимээ гарна
 - С. Цусан хангамжийн өөрчлөлт
 - Д. Мөчинд саа
 - Е. Өлгийдөхөд өвдөлт мэдэрч шалтгаангүйгээр уйлна
- /68./ Голомтоос зайдуу шахах, сунгах аппарат ямар шалтгаантай хугарлын үед эсрэг заалттай вэ?
- А. Остеомиэлит
 - В. Остеохондропатий
 - С. Периостит
 - Д. Ясны сүрьеэ
 - Е. Ясны хавдар
- /69./ Аварга эст хавдрын эмчилгээ:
- А. Химийн эмчилгээ

- В. Мэс заслын эмчилгээ туяаны эмчилгээний хослоно
С. Захалсан тайралт хийж аплопластик нөхөлт хийнэ
D. Үеэлбэр /сегмент/-ийн хагалгаа хийнэ /үе орчмын тайралт хийх, алло нөхвөр хийх, эсвэл үений эндопротез тавина
E. Мэс заслын бус эмчилгээ
- /70./ Хүнд хам гэмтэл мөчний хугаралд өвчин намдаах хэсгийн хориг хийх гол хүчин зүйл аль нь вэ?
A. Артерийн даралтыг бууруулахгүй байх
B. Биеийн температурыг бууруулах
C. Удаан хугацаагаар өвчин намдаах үйлчлэлийг хангах
D. Өвчин бүрэн намдаах нь эмнэл зүйн ажиглалтанд саад болохгүй байх
E. Төвийн венийн даралтыг нэмэгдүүлэх
- /71./ Густило-Андерсоны ангилал II-т тохируулан хэрэглэх эмчилгээний арга барил аль нь зөв бэ?
A. Битүү хугарлын эмчилгээ.
B. Шархыг өргөсгөж угааж цэвэрлэж гуурс тавина
C. Булчин хэсгийн тэжээлтэй шилжүүлнэ.
D. Цусан хангамжийг сэргээх хэрэгтэй
E. Аль ч үйлдлийг хийж болно
- /72./ Мөрний үений гэмтлээс үүссэн өвдөлтийн шинжтэй (плече-лопаточный периартрит) үед ямар хориг хийх вэ?
A. Арьс булчингийн мэдрэл
B. Далны дээд мэдрэл, далны доод хонхор талаас
C. Далны дээд хонхор талаас, далны дээд мэдрэлд
D. Бугалганд шууны мэдрэлд
E. Бугалаганд, богт болон дундын мэдрэлд
- /73./ Дээд мөчдийн “Compartment syndrom” эрт илрэх шинж тэмдэг
A. Хуруунууд хөхөрнө
B. Хуруунууд цайна
C. Шууны артерт лугшилт илрэхгүй
D. Өвдөнө.
E. Шууны нугалагчид саажина
- /74./ Гавал тархины ил гэмтэл гэж юу вэ?
A. Хуйханд шарх үүсэх
B. Гавлын яс хугарах
C. Шарх үүсч гавлын аль нэг хэсэгт яс хагарах
D. Шарх, хугарал 1 түвшинд
E. Гавлын яс цөмөрч, хатуу хальсаа гэмтээнэ
- /75./ Стандартын гөлтгөнөн коксет боолтыг хийхэд хэдэн давхар бэлдэх вэ?
A. 4-5
B. 6-7
C. 8-9
D. 10-12
E. 16-18
- /76./ Битүү гөлтгөнөн боолтыг тавьсны дараа ямар хүндрэл илүүтэй вэ?
A. Холголт үүсгэнэ
B. Арьсны идэвхигүй бичил биет үхэж, цаашид мөөгөнцөрөөр солигдоно
C. Мөч тэжээгч гол судсыг дарж цусгүйжилт үүсэх
D. Мэдрэлийн судлыг дарж неврит үүсгэнэ
E. Байнгын өвдөлт өгнө
- /77./ Гавал тархины гэмтлийг Глазгогийн шаталбараар хэдэн оноотой байвал комын байдалтай гэж үзэх вэ?
A. 10-11 балл
B. 4-8 балл
C. 1-3 балл
D. 14-15 балл

Е. 12 балл

- /78./ Түнхний төрөлхийн мултралыг хэдэн наснаас эхлэн мэс заслаар эмчлэх нь үр дүнтэй вэ?
- А. Нярай үеэс
 - В. 1-2 нас
 - С. 2 наснаас
 - Д. 5-10 наснаас
 - Е. 10 наснаас
- /79./ Шууны доод гуравны нэг хэсэгт дундын мэдрэл хаана байрлах вэ?
- А. Хуруунуудын өнгөц ба гүн нугалагч булчингуудын завсар
 - В. Алагны урт булчин болон сарвууны шууны нугалагч булчингийн хооронд
 - С. Хуруунуудын гүнзгий нугалагч булчин болон эрхий хурууны нугалагч булчин хооронд
 - Д. Гүн нугалагч булчингийн завсар
 - Е. Хуруунуудын өнгөц нугалагч булчин болон богтны нугалагч булчин хооронд
- /80./ Терес холбоонд хамгийн их дарагдал, чангарал өгдөг нь түнхний үений ямар байрлалд байх вэ?
- А. Гуя алцайсан байрлал (Abduction) түнхний үеэр нугалсан болон гадагш эргэсэн
 - В. Түнхээр тэнэгэр, гуя хавчсан (Adduction) байрлалд
 - С. Гуя хавчсан байрлалд үеэр гадагш эргэж, нугалсан байрлалд
 - Д. Гуя хавчсан, үеэр дотогш эргэж, нугалсан байрлалд
 - Е. Гадагш болон дотогш эргэсэн байрлалд
- /81./ Өвдөгний үеийг хиймлээр сольсны дараа эхний сард өвдөх хамгийн бага шалтгаан аль нь вэ?
- А. Халдвар
 - В. Үрэлтээс хугарал үүсэх
 - С. Протез зөв биш тавигдсанаас
 - Д. Зөөлөн эд хавчуулагдах
 - Е. Зөөлөн эдийн тэнцвэржилт муугаас тогтворгүй болох
- /82./ Хүзүүний доод нугалмын арын холбоосын эмчилгээний арга барилыг заана уу?
- А. Эвийн эмчилгээ хийж хатуу ортезыг хүзүүнд тавих
 - В. Мэс заслын эмчилгээ
 - С. Мэдрэлийн хүндрэлээс сэргийлэх эвийн эмчилгээ
 - Д. Halo vest 6-7 долоо хоног тавих
 - Е. Зөөлөн ортез тавих
- /83./ Өвдөгний үенд хатгалтыг хаагуур хийх вэ?
- А. Тойгны дээд орой буюу суурь түвшингээс 1-2 см арагш
 - В. Тойгны хажуу талаас 3-4 дотор тал буюу гадна талаас
 - С. Өвдөгний үений дотор талаар шилбэний шаант ясны урд барзгарын түвшинд
 - Д. Тойг долгиж байгаа түвшинд
 - Е. Тойгны доошно
- /84./ Төрөлхийн майга тавхайтай өвчтөн явахдаа:
- А. Доголоно
 - В. Доголохгүй
 - С. Явахдаа хөлөө ээлжлэн тавьж явах
 - Д. Тавхайн дотор захаар гишгэнэ
 - Е. Тавхайн гадна захаар гишгэнэ
- /85./ Зөөлөн эдийн /мөчдийн/ дарагдлын үед гарах эмгэг өөрчлөлт
- А. Элгэнд зогсонгошил үүсэх
 - В. Тархи, нугас цусаар дүүрэх
 - С. Булчин миоглобиноор ханах
 - Д. Уушиг хавагнаж, цээжний гялтанд цэгэн цус харвалт өгнө.
 - Е. Нойр булчирхайд цус харвах
- /86./ Галляцын хугарал ямар ясан дээр тохиолдох вэ?
- А. дунд чөмөг
 - В. атгаал яс
 - С. сарвуу яс
 - Д. шуу, богтос

Е. шилбэ яс

/87./ Түлэгдлийн шокын аль зэрэгт индекс франк нь 30-70 байх вэ?

- A. Хөнгөн
- B. Дунд
- C. Хүнд
- D. Маш хүнд
- E. Үхлийн өмнө

/88./ Төрөлтийн үед хүүхдэд гарч болох хагд үеийн гэмтэл /эпифизеолиз/ ямар мөчинд, аль түвшинд илүүтэй тохиолдож болох вэ?

- A. Атгаал чөмөгний эхлэх хэсэгт
- B. Атгаал чөмөгний төгсгөл хэсэгт
- C. Дунд чөмөгний эхлэх хэсэгт
- D. Дунд чөмөгний төгсгөл хэсэгт
- E. Шаант чөмөгний эхлэх хэсэгт

/89./ Гэмтлийн дараах плеврийн хөндийд цус хурахад авах арга хэмжээ

- а/ Хүзүүний вагосимпатик хориг
- б/ 8-р хавирга завсраар далны шугамаар плеврийн хөндийд гуурс тавина
- в/ Хурсан цусыг эргүүлж сэлбэнэ.
- г/ Судсаар өндөр молекулт шингэн юүлнэ
- д/ 2-р хавирга завсраар эгмийн дунд шугамаар гуурс тавина
- е/ Эмнэлэгт хэвтүүлнэ

- A. а, в, д
- B. б, г, е
- C. а, б, е
- D. а, д, е
- E. в, г, д

/90./ Хүүхдэд гэмтлийн эпифизеолиз аль хэсэгтээ илүү байрших вэ?

- A. Мөгөөрсний өсөлтийн ялтас болон эпифизийн хооронд
- B. Өсөлтийн пластинкийн пролиферацийн бүсэд
- C. өсөлтийн пластинк гипертрофийн бүсэд
- D. өсөлтийн пластинкийн окостенения бүсэд
- E. Аль алинд ч

/91./ Мөчний олон хугарал, хам гэмтлийн эрт нас баралтын голлох шалтгаанд аль нь вэ?

- A. Цус алдалт
- B. Гавал тархины гэмтэл
- C. Амьдралын чухал эрхтэний гэмтэл
- D. Гэмтэл шок III, IV зэрэг
- E. Тулгуур хөдөлгөөний эрхтэний гэмтэл

/92./ Шаант чөмөгний дээд хэсэг /эхлэх хэсэг/ хугаралд хүнд механизмаар үүсгэгдсэн хэдэн хувьд хайрцагны хам шинж илэрч болох вэ?

- A. 10%-д
- B. 20%-д
- C. 25%-д
- D. 20-40
- E. 5%-д

/93./ Ясны цочмог үрэвслийн эрт оношлох үндсэн арга нь юу вэ?

- A. Цусны ерөнхий шинжилгээ
- B. Ясны зураг 2 байрлалаар авах
- C. Чанд авиан шинжилгээ
- D. Ясанд хатгалт хийх /остеопункция/
- E. Компьютерийн томографи

/94./ Чөмөгт ясны хугаралд голомтоос зайдуу хадах мэс заслын аргыг хэрэглэж болохгүй заалт

- A. Хуурамч үе остеомиэлиттэй хосолсон бол
- B. Хуурамч үе, сорви хүнд өөрчлөлттэй хосолсон /арьс тэр орчиндоо, тэр түвшиндээ хам/

- С. Фиброзный хуурамч үе
D. Арьсны байдал харьцангуй сорвижилт хуурамч үенд
E. Хуурамч үе ясны дутмагшил ихтэй
- /95./ Остеохондрозыг оношлох үндсэн аргууд нэрлэнэ үү?
A. Эмнэлзүйн
B. Компьютерная томография
C. Рентген
D. Цөмийн шинжилгээ
E. Эмнэл зүй, рентген
- /96./ Гуяны төвшинд тайралтын дараа гуя хавчих хүчийг сулрахаас сэргийлж ямар арга хэмжээ авах вэ?
A. Гуя хавчигч том булчинг, гуяыг хавчмал байрлалд гуяны гадна талд холбох /миодез/
B. 4 толгойт булчинг тахимны шөрмөстэй холбох болон гуя хавчих булчинг гуяны өргөн ханчиртай холбох
C. Протезийн аягыг гуя хавчмал байдалд тохируулах
D. Хагалгааны өмнө гуя хавчих булчингийн дасгалыг идэвхитэй хийх
E. Хагалгааны дараа гуя хавчих булчингийн дасгалыг идэвхитэй хийх
- /97./ Гавал тархины гэмтлийг Глазгогийн шаталбараар хэдэн оноотой байвал ухаан балартах гэж үзэх вэ?
A. 10-11 балл
B. 11-12 балл
C. 6-7 балл
D. 13-14 балл
E. 8 балл
- /98./ Дунд чөмөгний хугарлын үед тавих гөлтгөнөн боолтын хэлбэр ямар байх вэ?
A. Аравч /Лонгет/
B. Нуруувч /Корсет/
C. Цавины шагай хүртэл /Тутор/
D. Түнхний үе оролцуулан /Коксит/
E. Чээж гартай хамт /Трохобрахиальный
- /99./ Бугалагны 3 толгойт булчингийн мэдрэлжүүлдэг мэдрэл аль нь вэ?
A. Дундын мэдрэл
B. Богтны мэдрэл
C. Шууны мэдрэл
D. Суганы мэдрэл
E. Арьс булчингийн мэдрэл
- /100./ Ширхэглүүрт шилжих ясны гаж хөгжил /Фиброзный остеодисплазия/ эмгэг голомт чөмөгт ясанд ямар байрлалаар тархах вэ
A. Өргөөшөө
B. Чөмөгний дагуу
C. Өсөлтийн дагуу
D. Метафиз хэсэг рүү шургаж
E. Дагуу, өргөөшөө аль алинд
- /101./ Сколиозоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг хүүхдийн дунд ямар насанд явуулах бэ?
A. Ерөнхий боловсролын сургуулийн 1 дүгээр ангиас
B. Ясли ,цэцэрлэгээс
C. Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангиас
D. Коллеж ,дээд сургуульд
E. Цэргийн албан хаагчдад
- /102./ Нурууны хугарлын тогтвортой, тогтворгүй байдал хэний ангилал вэ?
A. Лобын
B. Николийн
C. Денис
D. Мике
E. Фрикман
- /103./ Шууны хугарамтгай хэсгээр нугарах хэлбэрийн хугарал

- A. Bennett-ийн хугарал
- B. Smith-ийн хугарал
- C. Monteggia-ийн хугарал
- D. Colles-ийн хугарал
- E. Glaeazzi-ийн хугарал

/104./ Өвдөгний төрөлхийн мултралыг дагалдаад ямар гажиг тохиолдож болох вэ?

- A. Хавтгай сариу тавхай /плоско-вальгус/
- B. Майга тавхай
- C. Дунд чөмөгний хүзүүний вальгус
- D. Нурууны душек битүүрээгүй
- E. Гипертрихез

/105./ Шарханд 2 дахь цэгцэлгээг мэс заслын аргаар хийх заалт юу вэ?

- A. Цэгцэлгээг гэмтсэнээс хойш 7 хоногийн дараа хийнэ.
- B. Мэс заслын анхдагч цэгцэлгээ үр дүнгүй болсон тохиолдолд
- C. Анхдагч цэгцэлгээний дараа /1-3 хоног/ шарханд хоёрдогч оёдол тавих.
- D. Арьсны дутмагшилд мэс заслын цэгцэлгээний дараа нөхөлт хийх
- E. 1 сарын дараагаар анхдагчаар цэгцэлгээг хийх

/106./ Беннетын хугарал, мултрал гэж юу вэ?

- A. хөлний эрхий хурууны угийн шивнүүр хугарах
- B. гарын эрхий хурууны 1-р шивнүүрийн ил хугарал
- C. гарны эрхий хурууны угийн шивнүүрийн төвийн хэсгийн метафизын хугарал мултрал
- D. гарын 1-р шивнүүрүүдийн зөөлөн эдийн гэмтэл, хугарал
- E. бүх хуруунуудын хугарал мултрал

/107./ Түлэгдлийн тав нь зузаарч ховхрохдоо гүнзгий шархлаа үүснэ.

- A. 2-р зэрэг
- B. 4-р зэрэг
- C. 3Б түлэгдэл
- D. 1-р зэрэг
- E. 3А түлэгдэл

/108./ Чангалуур боолт тавих хугацаа

- A. Зун 2 цаг, өвөл 1 цаг
- B. Зун 1 цаг, өвөлд 2 цаг
- C. Өвөл зунд адилхан 2 цаг
- D. Зун 1,5 цаг өвөл 30 мин
- E. Жилийн аль ч улиралд 30 мин

/109./ Хондрома ихэвчлэн:

- A. Нурууны бие хэсэгт
- B. чөмөгт ясны диафизд
- C. Тавхай болон сарвууны жижиг яснуудад
- D. өвчүү хавирга
- E. Аль ч хэсгийг хамарна

/110./ Дунд чөмөгний гандан хэсгийн хугарлын доод түвшинг заана уу?

- A. Бага эргүүлгээс доош 4-4.5 см
- B. Бага эргүүлгээс доош 5 см
- C. Өвдөгний үеэс дээш 8 см
- D. Өвдөгний үенээс 7 см дээш
- E. Аль нь ч адилхан

/111./ Бороо удааширсан болон хугарлаар бороолохгүй байгаагийн үндсэн шалтгаан

- A. Судаснууд гэмтэх
- B. Ясыг уртааш нь хангалтгүй татсанаас
- C. Бэхэлгээг зөв биш хийгдсэнээс гадна
- D. Бэхэлгээг эрт өөрчилснөөс гадна
- E. Зах хязгаарын болон эргэлтийн зөрөөтэйгээс

/112./ Гүйдлийн утас нь газардсан, гүйдэлд цохиулсан хүнд, хамгаалалтын гуталгүйгээр яаж дөхөж очих вэ?

- A. Гүйж очно

- B. Түргэн алхана
 - C. Гутлаа газраас салгахгүй явж очно
 - D. Харайж хүрнэ
 - E. Дээрхи бүгд
- /113./ Тархины дунд зэргийн няцралын үед ухаан алдалтын хугацааг заана уу?
- A. Ухаан алдалт 0-5 минут үргэлжилнэ
 - B. Ухаан алдалт 1 цагаар үргэлжилнэ
 - C. Хэдэн секунд үргэлжилнэ
 - D. Ухаан алдалт 45 мин үргэлжилнэ
 - E. Ухаан алдалт 25-30 мин үргэлжилнэ
- /114./ Алганы Thenar булчингийн хөдөлгөөний мэдрэл
- A. n.medianus – хөдөлгөөний салаа
 - B. n.medianus – арьсны салаа
 - C. n.ulnaris – гүн салаа
 - D. n.ulnaris – өнгөц салаа
 - E. n.ulnaris – хөдөлгөөний салаа
- /115./ Дотуур цус алдалттай цээжний нэвтэрсэн гэмтэлд түргэн тусламжийн эмчийн баримтлах арга барил
- а/ Полиглюкин тарина б/ Реополиглюкин тарина
в/ Хавирга завсрын новокайны хориг г/ Викасол, ЕАК тарих
д/ Даралттай ариун боолт хийнэ
- A. а, в, д
 - B. б, в, г
 - C. а, г, д
 - D. в, г, д
 - E. а, б, д
- /116./ Өвдөгний үений хэв гажих остеоартроз хөгжих жам
- A. Васкулярная онол
 - B. Механик үйл ажиллагааны онол
 - C. Макро болон микро гэмтэл
 - D. Мэдрэл тэжээлийн онол
 - E. Үрэвслийн
- /117./ Сколиоз эвийн эмчилгээнд нуруувчийг /корсет/ ямар зорилгоор хийх вэ?
- A. Нурууны муруйлтыг засах
 - B. Хэлбэр дүрс алдагдалтыг зогсоох
 - C. Хагалгаанд бэлтгэх
 - D. Булчин суллах
 - E. Нурууны хөдөлгөөнийг хязгаарлах
- /118./ Гавал тархины хүнд гэмтэлтэй өвчтөн өндөр халуурах нь аль шалтгаантай холбоотой вэ?
- A. Архаг идээт үрэвсэл хурцдах
 - B. Төвийн гаралтай
 - C. Гавлын доторхи гэмтэл, идээт үрэвсэлтэй хавсрах
 - D. Организмын хариу урвал
 - E. Эмийн бодисын хариу урвал
- /119./ Галлеацийн хугарал мултрал аль нь вэ?
- A. Тохойн үе мултарч, нөгөө гарын шуу яс гандан хэсгийн доод/3 түвшинд
 - B. Тохойн үе мултарч, залаа сэртэн хугарах
 - C. Сарвуу мултарч, шуу ясны гандан хэсэг доод/3 түвшинд хугарах
 - D. Шуу яс гандан хэсгийн доод/3 түвшинд хугарч тохойн үе мултрах
 - E. Шуу ясны гандан хэсэг доод/3 түвшинд хугарч, богт чөмөгний толгой мултрах
- /120./ Түнхний төрөлхийн мултралд хийгдсэн мэс заслын эмчилгээний дараа гөлтгөнөн боолтыг аваад юу хийх вэ?
- A. Физик эмчилгээ, идэвхигүй дасгал
 - B. Идэвхитэй хөдөлгөөн
 - C. Шавар эмчилгээ

- D. Усан эмчилгээ
- E. Ачаалал өгч явуулна

/121./ Шарханд мэс заслын анхдагч цэгцлэгээ хийхэд гол хийх үйлдэл юу вэ?

- A. Шархыг ариутгах
- B. Цус, цусны үлдэгдэл, гадны биетийг авах
- C. Амьдрах чадваргүй бүх эдийг зүсч авах
- D. Арьсны зах ойролцоох эдийг тэнцүүхэн боломжоор авах
- E. Цусны нөжийг авч, дахин цус алдахаас урьдчилан сэргийлж цус алдаж буй судасыг боох

/122./ 137. Ямар үеэлбэр /сегмент/ хугарахад алга тосох байрлалд гөлтгөнөн тавих вэ

- A. богтос ясны дунд 1/3
- B. богтос ясны дээд 1/3
- C. шуу ясны дунд 1/3
- D. шуу ясны дээд 1/3
- E. богтос шуу ясны дунд 1/3

/123./ Түлэнхийн шокоос түлэнхийн хордлогын үе рүү шилжихэд ямар үзүүлэлтийг авч үзэх вэ?

- A. Шээсний гаралт хэвийн байх
- B. Температур ихсэх
- C. Шарх идээлэх
- D. Тахикардия
- E. Артерийн даралт ихсэх

/124./ Нохойд хазуулсан үед үзүүлэх анхны яаралтай тусламж

- а/ Шархыг устөрөгчийн хэт эслийн уусмалаар угаана
- б/ Преднизолон тарина
- в/ Ариун боолт хийнэ
- г/ Гэмтлийн цэгт хүргэнэ
- д/ Шархыг оёно

- A. а, б, г
- B. а, в, д
- C. а, в, г
- D. б, г, д
- E. б, в, г

/125./ Ясны төрөлхийн хэврэгшил /Несовершенны остеогенез/ /ЯТХ/ ангиллаар

- A. Хондродисплазия
- B. Остеодисплазия
- C. Гиперостозом
- D. Костный эозинофиль
- E. Остеохондродисплазия

/126./ Дунд чөмөгний булууны дээгүүр хугарлыг өвдөгний үенээс дээш хэдэн см-т тооцох вэ?

- A. 10 см
- B. 5 см
- C. 8 см
- D. 12 см
- E. Аль нь ч болно

/127./ Нүүрний хүнд гэмтлийн үед цус тогтоолтыг зогсоох зорилгоор аль артерийн судсыг боох вэ?

- A. Гүрээний гадна артери
- B. Гүрээний дотор артери
- C. Атгаал чөмөгний толгойн хэсэгт
- D. Гүрээний ерөнхий артери
- E. Чамархайн артери, түүний салаанууд

/128./ Цахилгаан гүйдэлд цохиулахад авах арга хэмжээ

- а/ Зохиомол амьсгал хийх
- б/ Шингэн ихээр сэлбэх
- в/ Гүйдлээс салгах

г/ Кордиамин тарих

д/ Зүрхний гаднах иллэг

А. а, б, в

В. а, в, д

С. б, г, д

Д. а, б, г

Е. в, г, д

/129./ Тархины хөнгөн зэргийн бяцралын үед компьютер томограммд гарах өөрчлөлтийг заана уу?

А. Гавлын дотор уйланхай үүсэх

В. Өөрчлөлт илрэхгүй

С. Гавлын дотор цус хурах

Д. Тархины хаваншилт

Е. Гавлын ясны хугарал

/130./ Шагайн ясны хугарахайд ямар шинж тэмдгүүд илрэх вэ?

А. Шилбэ-тавхайн үеэр тэнийлгэх, ул тийш хөдөлгөөн /нугалах/ хязгаарлагдана

В. Өсгий, шагайн үеэр хөдөлгөөн ихэснэ

С. Борвины шөрмөсний цөм хэсэгт цочмог өвдөнө, тавхай өлмий тийш хөдөлгөхөд хүчтэй өвдөнө, өсгийд тогшиход хугарлын түвшинд өвдөлт ихэснэ, хөлийн I хуруу ул тийш нугалсан байдалтай байна

Д. Гадна дотор хавчаарын хэлбэр өөрчлөгдөх

Е. Шилбэ тайвхайн үеэр хөдөлгөөн хэвийн байна

/131./ Чигчий, ядам хурууг мэдрэлжүүлэгч мэдрэл

А. n.medianus

В. n.Radialis

С. n.ulnaris

Д. n.suralis

Е. n.brachialis

/132./ Хэвлийн ил гэмтэлтэй, гэдэсний гогцоо нь гарсан тохиолдолд ямар тусламж үзүүлэх вэ?

а/ Шарханд хуурай боолт хийнэ

б/ Гэдэсний гогцоог буцааж оруулна

в/ Фурациллин новокайнтай эмтэй боолт хийнэ

г/ Кордиамин тарина

д/ Өвчин намдаагч хэрэглэнэ

е/ Дамжуургаар яаралтай эмнэлэгт хүргэнэ

А. а, б, г

В. б, г, д

С. в, д, е

Д. а, б, д

Е. а, г, д

/133./ Өвдөгний хэв гажих деформирующая остеоартрозын үндсэн шалтгаан

А. Өвдөгний үений гэмтэл /үен доторхи хугарал, үе үүсгэгч яснууд зөв биш бороолсон, өвдөгний үений холбоосууд, механикийн гэмтэл, үений мултралын үлдэцээс/

В. Тойгны төрөлхийн мултрал

С. Кенигын өвчин

Д. Үрэвсэл

Е. Хувьсах /инволюция/

/134./ Нурууны мултралын өнцгийг хэмжих энгийн хялбар арга

А. Абалмасовийн арга

В. Коббын арга

С. Фергюсонын арга

Д. Конагийн арга

Е. Масловийн арга

/135./ Бүсэлхий сээр нурууны нугалмын шахагдсан хугарлыг сэргээн засах эмчилгээ хийх.

А. 2-10 хоногт эрүүл ахуйн ерөнхий дасгал /амьсгал/ дээд, доод мөчийг бүрэн биш хэмжээгээр 10 илүүгүй хөдөлгөнө

- В. 10-20 хоногийн дараа хэвлий, нурууны булчин бэхжүүлэх, дээд мөчний үеэр бүрэн хэмжээгээр 20 удаа хөдөлгөн хоногийн сүүлчээр хэвлийгээр эргэнэ
- С. 20-60 хоногт дасгалыг 10-15 удаа давтаж үеэр 30-аас дээш хөдөлгөн хийнэ
- Д. 60-80 хоногт өвчтөнг босоход бэлтгэж 10-20 минутаар суулгана.
- Е. Физик эмчилгээ хослоно

/136./ Монтеджийн хугарал-мултрал аль нь вэ?

- А. Нэг гарт шуу яс мултарч, нөгөө гарт хугарал тохиолдоно
- В. Шуу ясны толгой мултарч, богт чөмөг гандан хэсгийн дунд болон дээд/3 хугарал нэг гарт тохиолдоно
- С. Сарвуу мултарч, шуу, богт чөмөгт гандан хэсгийн дунд/3 түвшинд хугарна
- Д. Тохойн үе мултарч, богт чөмөг гандан хэсгийн доод/3 түвшинд хугарна
- Е. Тохой мултарч шуу ясны гандан хэсэг дунд/3 түвшинд хугарна

/137./ Төрөлхийн мултралыг засах эвийн эмчилгээнд ямар хүндрэл гарч болох вэ?

- А. Үений толгой үхжих
- В. Суудлын мэдрэл саажих
- С. Түнхний үеэр хөдөлгөөнгүй болох
- Д. Үеэр байнгын өвдөлттэй
- Е. Үений үрэвсэл

/138./ Ясны уйланхай /киста/-н эмчилгээг сонгоно уу?

- А. Зөвхөн туяаны эмчилгээ
- В. Зөвхөн хатгалт хийж авах
- С. Эвийн эмчилгээ үр дүн өгөхгүй бол мэс заслын эмчилгээ
- Д. зөвхөн мэс заслын эмчилгээ
- Е. Зөвхөн химийн эмчилгээ

/139./ Эгэмний яс голдуу аль төвшиндөө хугардаг вэ?

- А. дунд 1/3-ээр
- В. гадна 1/3-ээр
- С. дотор 1/3-ээр
- Д. гадна дунд 1/3-ын уулзвараар
- Е. Дунд дотор 1/3-ын уулзвараар

/140./ Зөвхөн тархины гэмтлийн үед хийх эмчилгээний чиглэл

а/ Өвдөлтийг намдаах

б/ Зүрхний бэлдмэл тарих

в/ Дамнуурганд толгойг хажуу эргүүлж хэвтүүлж зөөвөрлөнө

г/ Магнийн сульфат булчинд тарина

д/ Дамнуурганд нуруугаар хэвтүүлж зөөвөрлөнө

е/ Хүчилтөрөгчөөр амьсгалуулна

- А. а, б, в
- В. г, д, е
- С. в, г, е
- Д. а, б, г
- Е. б, г, д

/141./ Олье өвчний үед мэс заслын эмчилгээ хийх тохиромжтой нас

- А. Сургуулийн өмнөх
- В. Сургуулийн
- С. Бэлгийн боловсролын үед
- Д. Насанд хүрсэн
- Е. Аль ч насанд болно

/142./ Дунд чөмөгний хүзүүний хугарлын үед илрэх шинж тэмдэгийг нэрлэнэ үү.

- А. Вернеллын шинж
- В. Розер Нелатоны шугам өөрчлөх
- С. Өсгийн наалдах шинж
- Д. Гуяа хавчих байрлалд байх
- Е. Ларрегийн шинж

/143./ Хүзүүний мэдрэлийн сүлжээнд хориг хийх нь аль нь зөв бэ?

- A. m.Sterno-Cleido-mastoideus-ийн дунд, ар захаар
- B. m.Sterno-Cleido-mastoideus булчингийн дунд, урд захаар
- C. 2-р хүзүүний түвшинд
- D. Хэлэн доорхи ясны түвшинд
- E. Эгэмээс дээш 2 см түвшинд

/144./ Түлэнхийн өвчтэй хүнийг үнэлэх үндсэн үзүүлэлтүүд

- а/ Түлэгдлийн талбай,
- б/ Зүрх судасны үйл ажиллагаа
- в/ Бөөрний үйл ажиллагаа
- г/ Түлэгдлийн гүн
- д/ Ухаан самуурах

- A. а, б, в
- B. б, в, г
- C. а, б, д
- D. а, в, г
- E. в, г, д

/145./ Түнхний үений гажиг хөгжлийн хүүхдийн амьдралын эхний саруудад тэргүүлэх шинж тэмдэг юу вэ?

- A. Мөч богиносох
- B. Арьсны нугалаас ижил биш
- C. Дюшенатрендленбургийн шинж тэмдэг
- D. Алцайлт хязгаарлагдана
- E. Мөч гадагш эргэсэн байдалтай

/146./ Гавал тархи нуруу нугасны үрэвсэл бүхий хүндэрсэн гэмтлийн үед антибиотик яаж сонгох вэ?

- A. Үрэвслийн үед пенициллиныг өндөр тунгаар хэрэглээд дараа нь бусад антибиотикийг сонгоно.
- B. Өвчтөний асуумжаас өөрт нь тохирох антибиотикийг хэрэглэнэ
- C. Цус ба хэсэг газрын үрэвслийн арчдаснаас авсан антибиотикийн мэдрэг чанарыг үндэслэнэ.
- D. Орчин үеийн өндөр хүчтэй антибиотикийг шууд хэрэглэнэ
- E. Бактериологийн шинжилгээг гартал

/147./ Шаант чөмөгний гандан хэсгийн бага хүчээр үүсгэгдсэн хугаралд тамхи татдаг өвчтөнд аль нь ямар хамаатай вэ?

- A. Эдгэрэх явц нь 4 дахин удаан
- B. Тамхи, татдаггүйд адилхан
- C. Энэ хугарал нь тамхичинд 1.5 дахин илүү тохиолдож, 2 дахин илүү удаан бороолоно.
- D. Тамхичинд 4 дахин илүү тохиолдоно, эдгэрэлт адил
- E. 4 Дахин их тохиолдоно, эдгэрэлт удаашрана

/148./ Эх барихын саажилт /дюшен эрба-хам шинж/ дээд мөчинд тэргүүлэх шинж тэмдэг аль нь вэ?

- A. Хуруу, сарвууны хөдөлгөөн байхгүй байна
- B. Мөр хавчсан, дотогш эргэлттэй байна
- C. Нэг талын саатай /төвийн гаралтай/
- D. Гар бүхэл дээ идэвхитэй хөдөлгөөнгүй
- E. Мөрний үеэр хөдөлгөөнтэй, хуруунууд хөдөлгөөнгүй

/149./ Яс түлэгдэх халууны хязгаарыг заана уу?

- A. 460С
- B. 510С
- C. 560С
- D. 610С
- E. 700С

/150./ Хавирга голдуу аль шугамаар хугардаг вэ?

- A. L A A
- B. L M S
- C. L M C

D. L A P

E. LAM

/151./ Түнхний үений деформирующая остеоартрозын эрт илрэх эмнэл зүйн шинж

A. Түнхний үеэр өвдөнө

B. Гуяны доод 1/3 хэсэг өвдөгний үеэр өвдөнө

C. Хавчих байрлалд контрактура үүснэ

D. Мөч богиносно.

E. Үеэр хавдана

/152./ Бүсэлхий мэдрэлийн сүлжээ ямар мэдрэлээс хэлбэржих вэ?

A. Th12-L4

B. Th12-L5

C. L1-L4

D. L1-L5

E. Th9-10

/153./ Сээр, бүсэлхий нурууны гэмтлийн механизмаар эмнэлзүйн ангилсан орчин үеийн бүх ангиллын суурь ангилал аль судлаачийнх вэ?

A. Nicoll

B. Holdsworth

C. Mc Afee

D. Kelly

E. Whitesid

/154./ Шууны ясны толгой хүүхдийн хэдэн насанд бүрэн мултарч болох вэ?

A. Нярай

B. 1 хүртэл

C. 1-3 нас

D. 4-7 нас

E. 5-12 нас

/155./ Өвдөгний үений мултралд артериография шинжилгээ хийх үү.

A. Артериография хийнэ

B. Мултралыг оруулсны дараа хийнэ.

C. КТГ хийнэ

D. Артериография хийхгүй

E. Өвдөгний үений рентген зураг эгц хажуугаас авна

/156./ Түнхний үений гаж хөгжил /дисплази/ эрт үед хийгдэх эмчилгээ

A. Эвийн

B. Гөлтгөнөн боолт

C. Үйл ажиллагааны чигүүд

D. Мэс заслын

E. Аль нь ч болно

/157./ Хүүхдийн атгаал чөмөгний булууны дээгүүрх хугарлыг битүү аргаар засахад эхлээд ямар үйлдэл хийх вэ?

A. Өргөөшөө зөрүүг засах

B. Уртааш зөрүүг засах

C. Өнцгөлсөн зөрүүг засах

D. уртааш, өргөөшөө зөрүүг засах

E. эргэлтийн зөрүүг засах

/158./ Уушигны голомтот сүрьеэгийн төгсгөлүүдийг нэрлэнэ үү?

1. Бүрэн шимэгдэнэ

2. Хатуурч шохойжсон голомт үүснэ

3. Задарч хөндийт сүрьеэ үүснэ

4. Уушгины бус эрхтэний сүрьеэ үүснэ

5. Гуурсан хоолойн сүрьеэ үүснэ

/159./ Сүрьеэгийн нянгийн эсрэг үйлчлэлтэй нэгдүгээр эгнээний эмийн бэлдмэлийг нэрлэнэ үү?

1. Изониазид

2. Рифампицин

3. Пиразинамид
 4. Этамбутол
 5. Бүгд зөв
- /160./ БЦЖ вакцины хэсэг газрын хүндрэлийг нэрлэнэ үү?
1. Хүйтэн буглаа
 2. Ханиалгах
 3. Захын тунгалгийн булчирхайн үрэвсэл
 4. хөлрөх
 5. Халуурах
- /161./ Сүрьеэгийн эмчилгээний 2-р бүлгээр ямар тохиолдлуудыг эмчлэх вэ?
1. Дахилт
 2. Тасалсан тохиолдол
 3. Үр дүнгүй эмчлэгдсэн тохиолдол
 4. Шинэ тохиолдол
 5. Архаг тохиолдол
- /162./ Анхдагч сүрьеэгийн ерөнхий шинжийг тоочно уу?
1. Бага насны хүүхэд өвчилнө
 2. Цусны их эргэлтээр тархах хандлагатай
 3. Тунгалгийг голдуу хамарч гэмтэнэ
 4. Зөвхөн уушгийг гэмтээнэ.
 5. Хурдан эдгэрнэ
- /163./ Химийн урьдчилан сэргийлэх эмчилгээний заалтыг нэрлэнэ үү?
1. Халдвартай хэлбэрийн сүрьеэтэй өвчтөний хавьтал
 2. Туберкулины сорил 10 мм-ээс дээш эерэг урвалтай
 3. Бусад шинжилгээ болон эмнэл зүйд сүрьеэ үгүйсгэгдсэн
 4. Туберкулины сорилд эерэг гарсан бүх тохиолдол
 5. Гэрлийн шинжилгээнд сүрьеэгийн бага зэргийн өөрчлөлттэй
- /164./ Уушгины хурц миляр сүрьеэгийн үед гэрлийн шинжилгээнд илрэх өөрчлөлтийг тодорхойлно уу?
1. Зөвхөн нэг талын уушгийг нэлэнхүйд нь хамарч жигд бус тархсан
 2. Хоёр талын уушгийг нэлэнхүйд нь хамарч жигд тархсан
 3. Жижиг болон дунд зэргийн хэмжээтэй голомтууд тодорхойлогдоно
 4. Олон тооны шар будаа шиг жижиг голомтууд тодорхойлогдоно
 5. Уушгинд “тамгалсан” хөндий үүссэн байна
- /165./ Сүрьеэгийн сэжигтэй тохиолдолд зайлшгүй хийх оношлогооны шинжилгээг тоочно уу?
1. Цусны биохимийн шинжилгээ
 2. Цэрний түрхэцийн шинжилгээ
 3. Туберкулины сорил
 4. Уушгины рентгенограмм
 5. Цэрний өсгөвөрлөх шинжилгээ
- /166./ Уушгины бүтэц эвдрэлт сүрьеэгийн үндсэн шинжийг тоочно уу?
1. Гуурсан хоолойн тэлэлт
 2. Нянгийн ялгаруулалт
 3. Амьсгалын дутагдал
 4. Уушгины эдийн бүтэц эвдрэл
 5. Уушгины эдийн сорвижилт
- /167./ Хүүхдийг сүрьеэгээс сэргийлэх өвөрмөц урьдчилан сэргийлэлтийн аргуудыг нэрлэнэ үү?
1. Сүрьеэтэй өвчтөний эмчилгээ
 2. БЦЖ вакцинжуулалт
 3. Дархлал дэмжих эмчилгээ
 4. Химийн урьдчилан сэргийлэх эмчилгээ
 5. Урьдчилан сэргийлэх үзлэг
- /168./ Сүрьеэгийн хагас идэвхитэй илрүүлэлтэнд хамрагдах хүрээг тодорхойлно уу?
1. Сүрьеэтэй өвчтөний хавьтал
 2. Гэр оронгүй хүмүүс
 3. Хоригдол

4. Оюутнууд
5. Залуус

/169./ БЦЖ вакцинаар үүсгэгдсэн дархлалтай хүүхдэд илрэх туберкулины сорилын хариу урвалын онцлогийг тоочно уу?

1. Сорилд үүссэн гүвдрүүний хэмжээ жил бүр ихэснэ
2. Сорилд үүссэн гүвдрүүний хэмжээ жил бүр буурна
3. Хэт эерэг урвалтай буюу 10 мм-ээс дээш хэмжээтэй гүвдрүү үүснэ
4. Эерэг урвалтай буюу 10 мм-ээс доош хэмжээтэй гүвдрүү үүснэ
5. Улайлт гүвдрүүнээс том хэмжээтэй байна

/170./ Уушигны голомтот сүрьеэгийн хүндрэлүүдийг нэрлэнэ үү ?

1. Нэвчдэст сүрьеэ
2. Плеврит
3. Хөндийт сүрьеэ
4. Туберкулема
5. Сорвит голомтот сүрьеэ

/171./ Цээжний хөндийн тунгалгийн булчирхайн сүрьеэгийн хүндэрлийг тоочно уу?

1. Анхдагч хөндий
2. Гуурсан хоолойн сүрьеэ
3. Сорвит хөндийт сүрьеэ
4. Ателектаз
5. Нурууны ясны сүрьеэ

/172./ Сүрьеэгийн эмчилгээний хоёрдугаар бүлгийн үргэлжлэх шатны эмчилгээнд хэрэглэх эмийн бэлдмэлүүдийг нэрлэнэ үү?

1. Изониазид
2. Рифамицин
3. Этамбутол
4. Стрептомицин
5. Пиразинамид

/173./ Казеоз хатгалгааны үед илрэх үндсэн шинжийг бичнэ үү?

1. Хурц эхлэл
2. Өндөр халуурах
3. Цэртэй, цустай цэртэй ханиах
4. Нойтон хэржигнүүр их хэмжээгээр сонсогдох
5. Хуурай ханиах

/174./ Сүрьеэгийн анхдагч бүрдэлийн бүрэлдхүүн хэсгүүдийг нэрлэнэ үү?

1. уушгины анхдагч голомт
2. уушгины тунгалгийн судасны үрэвсэл
3. уушгины угийн тунгалгийн булчирхайн үрэвсэл
4. уушгины олширсон зураглал
5. захын тунгалгийн булчирхайн үрэвсэл

/175./ Хүүхдийн сүрьеэгийн оношлогоонд хэрэглэх гол шинжилгээний аргуудыг нэрлэнэ үү?

1. Цэрний шинжилгээ
2. Гэрлийн шинжилгээ
3. Томографийн шинжилгээ
4. Туберкулины сорил
5. Эдийн шинжилгээ

/176./ Мантугийн сорилын хариу урвалыг хүүхдэд хэдэн мм байвал эерэг урвал гэж тооцох вэ?

1. Гүвдрүү 10 мм
2. Гүвдрүү 4 мм ба түүнээс доош хэмжээтэй
3. Гүвдрүүний хэмжээ хамаарахгүйгээр үхжил, цэврүү үүсэх
4. Гүвдрүү 2 мм хэмжээтэй
5. Гүвдрүүгүй улайлт үүсэх

/177./ Цээжний хөндийн тунгалгийн булчирхайн сүрьеэгийн клиник-рентгены хэлбэрүүдийг нэрлэнэ үү?

1. Бага хэлбэр
2. Нэвчдэст хэлбэр

3. “Хавдар” төст хэлбэр
4. Шинж тэмдэггүй хэлбэр
5. Хүндрэлтэй хэлбэр

/178./ Орчин үеийн сүрьеэгийн эмчилгээний зарчмыг сонгоно уу?

1. Эмчилгээг завсарлагаатай хийх
2. Шууд хяналттай эмчлэх
3. Нэг юмуу хоёр эмийг хосолж хэрэглэх
4. Богино хугацаагаар эмчлэх
5. Урт хугацааны эмчилгээний горимыг сонгох

/179./ Уушгины гэрлийн шинжилгээнд уушигны ямар эмгэгийн үед цагираг сүүдрийн хам шинж илрэх вэ?

1. Гуурсан хоолойн гаралтай уулинхай
2. Хавдарын задрал
3. Хөндийт сүрьеэ
4. Уушгины голомтот сүрьеэ
5. Туберкулема

/180./ Дэлбэнгийн нэвчдэст сүрьеэгийн (лобит) үед илрэх үндсэн шинжүүдийг тоочно уу?

1. Эмнэл зүйн шинж тод илэрсэн
2. Уушгийг тогшиход дэлбэн хамарсан тогшилтын чимээ бүдгэрсэн
3. Цэрний түрхэц эерэг
4. Эмнэл зүйн шинж тэмдэггүй
5. Эмнэл зүйн шинж бүдэг илэрсэн

/181./ Туберкулины сорилыг ямар зорилгоор хийх вэ?

1. Нөхөн вакцинжуулалтанд хамрагдах хүүхдийг сонгох
2. Хүүхдэд сүрьеэгийн халдварыг эрт илрүүлэх
3. Сүрьеэгийн халдварын жилийн эгзэгийг тодорхойлох
4. Уушигны бус эрхтэний сүрьеэтэй тохиолдлыг оношлох
5. Сүрьеэгийн эмчилгээний хяналтыг хийх

/182./ БЦЖ вакцин хийх заалтыг нэрлэнэ үү?

1. Туберкулины сорилд эерэг хүүхэд
2. Бага насны хүүхдэд
3. Бүх насны хүүхдэд
4. Гүйцэд, эрүүл нярай хүүхдэд
5. Сүрьеэгээр өвчлөөгүй хүүхэд

/183./ Сүрьеэгийн нянг устгах ариутгалын уусмалыг нэрлэнэ үү?

1. Хлорамины уусмал
2. 5% фенол
3. Спирт
4. 2% лизол
5. Давсны хүчил

/184./ Уушигны голомтот сүрьеэгийн үед бодит үзлэгт ямар өөрчлөлтүүд илрэх вэ ?

1. Цээжний хэнхэрцэг өөрчлөлтгүй
2. Тогшилтоор болон чагналтаар онц өөрчлөлтгүй
3. Цээжний хэнхэрцэг 2 талд амьсгалд жигд оролцоно
4. Их хэмжээний хуурай нойтон хэржигнүүр сонсогдоно
5. Цээжний хэнхэрцэг торх хэлбэртэй болсон байна

/185./ Хүүхдийн анхдагч сүрьеэгийн оношлогоонд өргөн хэрэглэх шинжилгээний аргуудыг тоочно уу?

1. Цусанд уургийн хэмжээг тодорхойлох
2. Туберкулины сорил
3. Цэрний түрхэцийн шинжилгээ
4. Уушгины гэрлийн шинжилгээ
5. Цэрний өсгөвөрлөх шинжилгээ

/186./ Сүрьеэгийн бронхаденитыг ялган оношлох өвчнийг нэрлэнэ үү ?

1. Лимфийн хавдрууд (лимфогрануломатоз, лимфосаркома, лимфолейкоз)
2. Төвийн гаралтай хорт хавдар

3. Өвөрмөц бус лимфаденопатии (корь, коклюш, вирусын халдварт өвчин г.м)
4. Уушигны голомтот хатгалгаа
5. Улаан хоолойн хавдар

/187./ Анхдагч сүрьеэгийн эмнэл зүйн хэлбэрүүдийг нэрлэнэ үү?

1. Сүрьеэгийн хордлого
2. Сүрьеэгийн бронхаденит буюу цээжний хөндийн тунгалгийн булчирхайн сүрьеэ
3. Сүрьеэгийн анхдагч бүрдэл
4. Нэвчдэст сүрьеэ
5. Хөндийт сүрьеэ

/188./ Уушгины халдвартай хэлбэрийн сүрьеэтэй өвчтөний хавьтал 5 настай хүүхдэд Мантугийн сорил тавьж, 72 цагийн дараа хариуг шалгахад 6 мм хэмжээтэй гүвдрүү жижиг цэврүүний хамт үүссэн бол энэ урвалыг юу гэж дүгнэх вэ? Цаашид авах арга хэмжээг тодорхойлоно уу?

1. Эерэг урвал
2. Эмнэл зүйн шинжүүд болон бодит үзлэгийн өөрчлөлтийг шалгана
3. Цээжний гэрлийн шинжилгээнд өөрчлөлттэй эсэхийг тодорхойлно
4. Цусны ерөнхий шинжилгээнд өөрчлөлттэй эсэхийг тодорхойлно.
5. Эмнэл зүй болон бусад шинжилгээнд сүрьеэгүй нь батлагдсан бол химийн урьдчилан сэргийлэх эмчилгээ хийнэ.

/189./ Сүрьеэгийн эмчилгээний хяналтыг явуулах чиглэлүүдийг нэрлэнэ үү?

1. Шууд хяналттай эмчлэх
2. Үр дүнгийн хяналт хийх
3. Гаж урвалын хяналт хийх
4. Биеийн жингийн хяналт
5. Цусны ерөнхий шинжилгээ хийх

/190./ Туберкулем даамжирч, задарсан тохиолдолд илрэх шинжүүдийг тоочно уу?

1. Цэртэй ханиах, цустай ханиах
2. Хордлогын хам шинж тод илрэх
3. Цэрний түрхэц эерэг гарах
4. Цусны шинжилгээнд өөрчлөлт илэрч, СОЭ хурдсах
5. Гэрлийн шинжилгээнд гэмтэлийн хэмжээ томорч, сүүдэр жигд бус болох

/191./ Уушигны голомтот сүрьеэтэй шинэ тохиолдлыг эмчлэх эмчилгээний бүлэг, хугацааг сонгоно уу?

1. Нэгдүгээр бүлэг, 4 сар
2. Хоёрдугаар бүлэг, 8 сар
3. Хоёрдугаар бүлэг, 6 сар
4. Гуравдугаар бүлэг, 6 сар
5. Гуравдугаар бүлэг 4 сар

/192./ Цээжний хөндийн тунгалгийн булчирхайн сүрьеэгийн үед бодит үзлэгээр илрэх өөрчлөлтийг бичнэ үү?

1. Эгэмний дээд хэсэгт тогшилтын чимээ бүдгэрнэ
2. Далны хооронд тогшилтын чимээ бүдгэрнэ
3. Эгэмний дээд хэсэгт жижиг нойтон хэржигнүүртэй
4. Чагнахад онцын өөрчлөлтгүй
5. Тогшилтоор өөрчлөлтгүй

/193./ Уушигны сүрьеэгийн сэжигтэй шинж тэмдэгүүдийг тоочно уу?

1. 21 хоногоос дээш хугацаанд ханиах
2. Цэр, цустай цэртэй ханиах
3. Цээжээр өвдөх
4. Халуурах, хөлрөх
5. Турах

/194./ Элгэнд хортой гаж урвал үүсгэх боломжтой сүрьеэгийн эмийн бэлдэмлүүдийг нэрлэнэ үү?

1. Изониазид
2. Рифамицин
3. Пиразинамид

4. Этамбутол
5. Стрептомицин

/195./ Уушгины сүрьеэгийн сэжигтэй шинжүүдийг тоочно уу?

1. 14 хоногоос дээш хугацаагаар ханиах
2. Цэртэй, цустай ханиах
3. Цээжээр өвдөх
4. Халуурч, хөлрөх
5. Турах

/196./ Эмэнд дасалтай сүрьеэ үүсэхээс сэргийлэхэд чухал ач холбогдолтой хүчин зүйл бол:

1. Сүрьеэг эрт илрүүлж, оношлох
2. Сүрьеэгийн эмчилгээг шууд хяналттай хийх
3. Сүрьеэгийн эмчилгээний хяналтыг үр дүнтэй явуулах
4. Эмийн гаж нөлөөг хянаж, сэргийлэх
5. Сүрьеэгийн эмчилгээг ганцхан эмээр дагнаж хийхгүй, зөв хослуулах

/197./ Уушгины гэрлийн шинжилгээнд тархмал сүүдрийн хам шинж ямар өвчнүүдийн үед илэрч болох вэ?

1. Уушигны милиар сүрьеэ
2. Хорт хавдарын метастаз
3. Уушиг тоосжих өвчин
4. Зогсонгишлын уушиг
5. Уушгины жижиг голомтот хатгалгаа

/198./ Мантугийн сорилын хариу урвалыг хэдэн цагийн дараа хэмжиж тодорхойлох вэ ?

1. 24 цаг
2. 72 цаг
3. 12 цаг
4. 48 цаг
5. 2 цаг

/199./ БЦЖ вакцин нь хүүхдийг ямар хэлбэрийн сүрьеэгээр өвчлөхөөс найдвартай хамгаалах вэ?

1. Уушигны бус эрхтэний сүрьеэ
2. Хурц тархмал сүрьеэ
3. Уушигны сүрьеэ
4. Сүрьеэгийн менингит
5. Анхдагч сүрьеэ

/200./ Цээжний хөндийн тунгалгийн булчирхайн сүрьеэгийн нэвчдэст хэлбэрийн үед эмнэл зүйд илрэх шинжүүдийг тоочно уу?

1. Хордлогын хам шинж
2. Уушиг-гуурсан хоолой, гялтангийн хам шинж
3. Захын тунгалгийн булчирхайн өөрчлөлт
4. Хоол боловсруулах замын хямрал
5. Толгойн хүчтэй өвдөлт

/201./ Цэрний түрхэцийн шинжилгээний давуутай талуудыг тоочно уу?

1. Хялбар
2. Богино хугацаанд хариу гарна
3. Халдвартай хэлбэрийн сүрьеэг оношилно
4. Оношийг найдвартай батална.
5. Хямд өртөгтэй

/202./ Уушгины хоёрдогч сүрьеэгийн ерөнхий шинжийг тоочно уу?

1. Голдуу насанд хүрэгсэд өвчилнө.
2. Цусаар тархахгүй, голдуу уушгийг голомтлог байдлаар гэмтэнэ
3. Задрах хандлагатай, эмчилгээ заавал шаардлагатай
4. Тунгалгийг хамарч гэмтээнэ.
5. Цусаар тархах хандлага өндөртэй

/203./ Томуугийн үүсгэгчийн шинжүүдийг түүж бич.

1. Ретровирус
2. Ортомиксовирус
3. ДНХ агуулсан
4. Хатаах буцалгахад амархан үхнэ
5. Гадаад орчинд тэсвэртэй

/204./ Герпес вирусын халдвараас сэргийлэх өвөрмөц арга нь аль вэ?

1. Анатоксин
2. Иммуноглобулин
3. Антибиотик
4. Нийлмэл вакцин
5. Вирусийн эсрэг бэлдмэлүүд

/205./ Сахуугийн үед элбэг тохиолдох хүндрэлүүдийг заа.

1. Гломерулонефрит
2. Миокардит
3. Синовит
4. Нефрит
5. Кератит

/206./ Урвах тахал өвчний баасны шинж чанарыг тэмдэглэ.

1. Усархаг
2. Хэмжээ их
3. Үнэргүй
4. Цусны судалтай
5. Хоолны үлдэцтэй

/207./ Халдвар хордлогын шокийн эмнэл зүйн зэргийн шалгуурт орох үзүүлэлтүүдийг тэмдэглэ.

1. Цусархаг тууралтын байдал
2. Артерийн даралтын түвшин болон Гведалийн шинж
3. Шээсний хэмжээ
4. Суулгалтын тоо
5. Гэдэс базлалтын тоо

/208./ Бруцеллез өвчний үед антибиотик эмчилгээ хийх заалтуудыг сонго.

1. Анхдагч далд хэлбэр
2. Цочмог хэлбэр
3. Үлдэц хууч
4. Үхжил - үсэрхийлсэн
5. Архаг үрэвсэл намдсан

/209./ Гепатитын А вирусийн халдварын дамжих хүчин зүйлийг тэмдэглэнэ үү?

1. Ус
2. Хоол хүнс
3. Бохир гар
4. Зүү тариур
5. Цус

/210./ Улаан эсэргэнэ өвчтөний царай ямар байх вэ?

1. Цонхигор
2. Хацар нь улайсан
3. Хамар уруулын гурвалжин хөх
4. Хамар уруулын гурвалжин цагаан
5. Зовхи хавдсан

/211./ Герпес вирус дараахь дэд бүлгүүдэд хуваагдана

1. Альфа
2. Гамма
3. Бетта
4. Сигма
5. Эпсилон

/212./ Гахай хавдрын эгэл хэлбэрийн эмчилгээг тэмдэглэ

1. УВЧ-ээр шарах

2. Бүлээн ба спиртэн бигнүүр
 3. Шүлс бага ялгаруулах шингэвтэр хоол
 4. Хацарт хүйтэн жин
 5. Цус тогтоох эмчилгээ зайлшгүй хийнэ
- /213./ Урвах тахал өвчний баасны шинж чанарыг тэмдэглэ
1. Усархаг
 2. Хэмжээ их
 3. Үнэргүй
 4. Цусны судалтай
 5. Хоолны үлдэцтэй
- /214./ Хөөмийн сахуугийн хордлогот хэлбэрийн үед ямар хүндрэлүүд илэрч болох вэ?
1. Хордлогот миокардит
 2. Тагнай, залгиурын саа
 3. Нефроз
 4. Менингит
 5. Уушгины хатгаа.
- /215./ В гепатитаас сэргийлэх тарилгыг тарих насыг зөв сонго.
1. Төрсний дараа 24 цагийн дотор
 2. 2 сартайд
 3. 3 сартайд
 4. 4 сартайд
 5. Бүгд зөв
- /216./ Халдвартын бүтэн боксонд ямар өвчтөнг хэвтүүлэх вэ?
1. Онош тодорхойгүй өвчтөн
 2. Агаар дуслын халдварт өвчтэй хүн
 3. Гоц халдварт өвчтэй
 4. Гэдэсний халдварт
 5. Бэлгийн замын халдварт өвчтэй
- /217./ Томуу өвчний эхлэл үеийн шинжүүдийг нэрлэ.
1. 38.5-40 хэм хүрч халуурна
 2. Толгой өвдөнө
 3. Үе мөч, булчингаар шархирч өвдөнө
 4. Ханиалгана
 5. Хамар битүүрнэ
- /218./ Менингококкийн халдварын үед дараахь хүндрэлүүд эрт үед тохиолддог
1. Халдвар хордлогын шок
 2. Тархины цочмог хаван
 3. Бөөрний цочмог дутал, бөөрний дээд булчирхайн цочмог дутал,
 4. Ларингит
 5. Цус алдалт
- /219./ Боомын үүсгэгч ямар хор ялгаруулах вэ?
1. Бүрхүүлийн
 2. Үхүүлэх хор
 3. Хавагнуулах
 4. Энтеротоксин
 5. Некротоксин
- /220./ Татрангийн өвөрмөц эмчилгээнд дараах бэлдмэлүүд орно:
1. Тайвшруулах, таталтын эсрэг бэлдмэлүүд
 2. Татрангийн хорын эсрэг ийлдэс
 3. Антибиотик
 4. Татрангийн иммуноглобулин
 5. Сульфаниламид
- /221./ Герпес вирусийн халдвараас сэргийлэх өвөрмөц арга нь аль вэ?
1. Анатоксин
 2. Иммуноглобулин
 3. Антибиотик

4. Вирүсийн эсрэг бэлдмэлүүд
 5. Нийлмэл вакцин
- /222./ Балнад өвчний халууралтын онцлог шинжүүдийг сонгоно уу?
1. Өдөр ирэх тутам даамжирна
 2. Хөлрөхгүй
 3. Арьс хуурай
 4. Халуунтай тохирсон тахикарди илэрнэ
 5. Чичирнэ, хөлөрнө
- /223./ Халдварт өвчний санаа авахуулах шинжид ямар шинжүүд хамаарах вэ?
1. Халуурах
 2. Дотор муухайрах
 3. Бие сулрах
 4. Туурах
 5. Баасны шинж өөрчлөгдөх
- /224./ Менингококкийн халдварын үеийн хожуу тохиолдох хүндрэлд дарааь хүндрэлүүд орно.
1. Халдвар хордлогын шок
 2. Эпилепсийн уналт
 3. Тархины цочмог хаван
 4. Тархины дотоод даралт ихсэх хамшинж
 5. Бөөрний дээд булчирхайн цочмог дутал
- /225./ Улаан бурхны хөнгөрүүлсэн /митигированная/ хэлбэрийн онцлог
1. Хөнгөн явцтай
 2. Нууц хагацаа урт
 3. Улайралтын шинж тэмдгүүд бүдэг
 4. Хүнд явцтай
 5. Тууралт дэс дараатай
- /226./ Элэгний эсийг дутлыг илтгэх биохимийн үзүүлэлтүүдийг сонго.
1. Альбумин буурах
 2. Протромбины индекс буурах
 3. Бета – липопротейд буурах
 4. Билирубин буурах
 5. Сульма буурах
- /227./ Балнад өвчний үед ямар халууралт байх вэ?
1. Вундерлихийн
 2. Килдюшевскийн
 3. Боткины
 4. Гектический
 5. Халуунгүй
- /228./ Influenza A вирүсийн бүрхүүлийн эсрэг төрөгчдийг тэмдэглэ.
1. Т-уураг
 2. Нейраминадаза
 3. М-уураг
 4. Гемагглютинин
 5. И-ацетилглюкозамин
- /229./ Бруцеллийн эмгэг төрүүлэгч чанарыг тэмдэглэнэ үү?
1. Гадар хор ялгаруулдаг
 2. Эд, эсэд нэвтрэх инвазив чанар сайн
 3. эсийн үхжил үүсдэг
 4. Эсийн дотор шимэгчлэн орших
 5. Тэжээлт орчинд хурдан ургана
- /230./ Гепатитын С болон Д вирүсийн халдвар дамжиж болох замуудыг сонго.
1. Агаар дусал
 2. Бэлгийн зам
 3. Хоол боловсруулах
 4. Арьс салстын шархаар
 5. Шавьж ба дамжуулагч

/231./ Улаан эсэргэнэ өвчний гаж хэлбэрт хамаатай шинжүүдийг сонго.

1. Нууц хугацаа 2-7 хоног
2. Ангина илрэхгүй
3. Тууралт нүүрнээс эхэлнэ
4. Арьс салстын бүрэн бүтэн байдал алдагдсан байна
5. Эрүүн дорхи лимфаденит болно

/232./ Гахай хавдар өвчний ид үед эмнэл зүйн ямар шинжүүд илрэх вэ?

1. Ам ангайж болохгүй өвдөнө
2. Хоёр талын шүлсний булчирхай хавдсан
3. Бага зэрэг халуурна
4. Толгой таллаж хүчтэй өвдөнө.
5. Маш их хэмжээгээр бөөлжинө

/233./ Улаан эсэргэнэ өвчний гаж хэлбэрт хамаатай шинжүүдийг сонго

1. Ангина тод илрэх
2. Ангина илрэхгүй
3. Тууралт нүүрнээс эхэлнэ
4. Арьс салст гэмтсэн байх
5. Хоолойн булчирхай үрэвсэх

/234./ Тархины цочмог хавангийн зэргийг дараах шинжүүд илэрхийлнэ.

1. Ухаан санааны байдал
2. Хүүхэн харааны урвал
3. Менингитийн шинжийг илрэх эрчим
4. Рефлекс
5. Хөхрөлт

/235./ IgG –ийн үндсэн шинжүүдийг тэмдэглэнэ үү?

1. Хожуу үед үүснэ
2. Нийт иммуноглобулины 70-80% эзэлнэ
3. Нэвчих , хавсарга холбох урвалд их идэвхтэй
4. Наалдуулах , задлах урвалд идэвхтэй
5. Эрт үед үүснэ.

/236./ Хөхүүл ханиалгын үеийн эмнэлзүйн өвөрмөц шинжүүдийг нэрлэ.

1. Угсруулсан ханиалга
2. Салсархаг зүйлээр бөөлжих
3. Аура буюу зөн совин болон реприз
4. Хоолой сөөх
5. Халуурах

/237./ Хүний биеийн өвөрмөц хамгаалах тогтолцоонд юу хамаарах вэ?

1. В - лимфоцит ба дархлааны ой дурсамж
2. түргэн зуурын хэт мэдрэг чанар
3. эсрэг бие үүсэх
4. Макрофаг
5. Шүлс,

/238./ Сальмонеллуудын эсрэг бие өвчний аль үед илрэх вэ?

1. Эхний 2 цаг дотор
2. 1 хоногийн дараа
3. 2-3 хоногийн дараа
4. Эхний 7 хоногийн сүүл, 2.3 дахь долоо хоногт
5. 2-12 цаг

/239./ Галзуу өвчний эхэн үед ямар шинжүүд илрэх вэ?

1. Айж сандрах
2. Нойронд муу
3. Шархны орчим өвдөх, хорсох ирвэгнэ
4. Халуурах
5. Гар хөл ирвэгнэж мэдээ алдах

/240./ Татрангийн таталтын онцлогийг тэмдэглэ

1. Өвдөлттэй

2. Их хүчтэй
 3. Татах үедээ ухаан алдахгүй
 4. Богино хугацааны
 5. Сул
- /241./ Балнад өвчний тууралт зонхилон хаана гардаг вэ?
1. Нүүрэн дээр
 2. Алга,улан дээр
 3. Гарын сарвуу, нуруун дээр
 4. Цээж хэвлий орчим
 5. Толгойн хэсгээр
- /242./ Герпес вируүсийн халдварын үед дараахь эмийн бэлдмэлүүдийг хэрэглэнэ
1. Ацикловир
 2. Рибавирин
 3. Алпизарин
 4. Видарабин
 5. Вальцикловир
- /243./ Төвөнхийн сахуугийн эмнэл зүйн шинжүүд юу вэ?
1. 38 хэм хүртэл халуурна
 2. Хоолой сөөж ханиана
 3. Төвөнхийн салстад зузаан өнгөр тогтдог
 4. Гүйлсэн булчирхай, хүүхэн хэл зузаан саарал өнгөртэй
 5. Гүйлсэн булчирай эмзэглэлтэй
- /244./ Тархины цочмог хавангийн зэргийг дараахь шинжүүд илэрхийлнэ
1. Ухаан санааны байдал
 2. Хүүхэн харааны урвал
 3. Мэнэнгийн шинжийн илрэх эрчим болон рефлекс
 4. Тууралтын байдал
 5. Халууралт
- /245./ Улаан бурхан өвчний халдвартай үеийг тэмдэглэ.
1. Нууц үеийн төгсгөл
 2. Улайралтын үе
 3. Тууралтын үе
 4. Нөсөөжилтийн үе
 5. Өвчний бүх үе шатанд
- /246./ Балнад өвчний үед тохиолдох онцлог шинжүүдийг сонгоно уу?
1. Өнгөртэй зузаан хэл
 2. Падалкийн шинж
 3. Филлипповичийн шинж
 4. Стефанскийн шинж.
 5. Гиппократын царай
- /247./ Цочмог вирүст хепатит өвчний шарлалтын өмнөх үед илрэхгүй хам шинжүүдийг сонго.
1. Элэг, дэлүү томрох
 2. Арьс, салст шарлах
 3. Мэнэн төст
 4. Томуу төст
 5. Ходоод гэдэс хямрах
- /248./ Балнад өвчний өвөрмөц бус хүндрэлийг тэмдэглэнэ үү?
1. Гломерулонефрит
 2. Дисбактериоз
 3. Усгүйжилт
 4. Нарийн гэдэснээс цус алдах
 5. Гэдэс цоорох
- /249./ Сахуугийн савханцар ямар хор фермент ялгаруулдаг вэ?
1. Гиалуранидаза
 2. Нейраминадаза
 3. Гадар хор

4. Дотор хор
 5. Цистиназа
- /250./ Архаг гепатит, элэгний цирроз, хавдарын шалтгаан болдоггүй вирусүүдийг тэмдэглэ.
1. Гепатитын С вирус
 2. Гепатитын А вирус
 3. Эпштейн Баррын вирус
 4. Гепатитын Е вирус
 5. Гепатитын D вирус
- /251./ Аденовируст халдварын үед ямар шинжилгээг хийх вэ?
1. Бактерлоги
 2. Вирусологи
 3. Харшлын
 4. Серологи
 5. Биологийн
- /252./ Гахай хавдрын үед шүлсний булчирхайн хавдрын онцлог ямар байх вэ?
1. Хавдар хатуу
 2. Хавдарын өнгө нь өөрчлөгдөөгүй
 3. Хавдсан хэсэг халуун, эмзэглэлтэй
 4. Хавдарын орчимд ямар ч өөрчлөлтгүй
 5. Хавдсан хэсгийн арьс улайсан
- /253./ IgM –ийн үндсэн шинжүүдийг тэмдэглэнэ үү?
1. Хожуу үед үүснэ
 2. Эрт үед үүснэ
 3. Нийт иммуноглобулины 70-80% эзэлнэ
 4. Наалдуулах, задлах урвалд идэвхтэй
 5. Нэвчих, хавсарга холбох урвалд их идэвхтэй
- /254./ Герпес вирусийн оношлогоонд лабораторийн дараахь аргуудыг хэрэглэнэ
1. Ийлдэс судлалын
 2. Вирус судлалын
 3. Эс судлалын
 4. Нян судлалын
 5. Биохимийн
- /255./ Цусан суулгыг оношлоход оношлогооны ямар аргуудыг голлон ашигладаг вэ?
1. Нян судлал
 2. Копрологи
 3. Серологи
 4. Фермент холбоот эсрэг биеийн урвал
 5. Вирус судлал
- /256./ Varicella Zoster вирусийн халдварын гаж хэлбэрүүдийг тэмдэглэ.
1. Том цэврүүт хэлбэр
 2. Үхжилт хэлбэр
 3. Цусархаг хэлбэр
 4. Хөнгөн хэлбэр
 5. Хүнд хэлбэр
- /257./ Хөхүүл ханиадын үүсгэгч нь дараахь эсрэг төрөгчидтэй.
1. Агглютиноген
 2. Гемагглютинин
 3. Протектив
 4. Дотор хор
 5. Гадар хор
- /258./ Сальмонеллезын ходоод гэдэсний хэлбэрт орохгүй хувилбарыг сонго.
1. Гастрит
 2. Балнад төст
 3. Гастроэнтерит
 4. Идээт үжил
 5. Гастро-энтероколит

/259./ Хиамдал өвчин үүсэх нөхцөл бол.....

1. Нөөшилсөн мөөг идэх
2. Нөөшилсөн өргөст хэмх идэх
3. Утсан махан бүтээгдэхүүн идэх
4. Жимсний чанамал идэх
5. Жимсний шүүс уух

/260./ Татрангийн эхлэл үеийн шинжүүдийг тэмдэглэ

1. Хараа муудах, зовхи буух
2. Тризм, сардоник инээмсэглэл
3. Амьсгаадалт, амьсгал бачуурах
4. Юм залгиж чадахгүй
5. Бөөлжих, халуурах, толгой өвдөх

/261./ Менингококцемийн үед илрэх өвөрмөц шинжийг тэмдэглэнэ үү?

1. Толгой хүчтэй өвдөх
2. Цусархаг тууралт гарах
3. Олон удаа бөөлжих
4. Гэнэт өндөр халуурах
5. Ухаан алдах

/262./ Боомын арьсны хэлбэр ямар байдлаар илрэх вэ?

1. Ёлом төст
2. Идээт
3. Цэврүүт
4. Буглаат
5. Шархлаат

/263./ Хиамдал өвчний үүсгэгчийн хорыг..... илрүүлнэ

1. Ходоод угаасан усанд
2. Хоолны үлдцэнд
3. Бөөлжисэнд
4. Өтгөнд
5. Цусанд

/264./ Архаг В гепатитын үед Интерферон эмчилгээ хийх үзүүлэлтүүдийг сонго.

1. Алат фермент хэвийн байх
2. HBe Ag / + /
3. Тимол өндөр байх
4. АлАт ферментийн идэвх 2-5 дахин их байх
5. Альбумины хэмжээ буурах

/265./ Улаан эсэргэнэ өвчний гаж хэлбэрт хамаатай шинжүүдийг сонго.

1. Нууц хугацаа 2-7 хоног
2. Ангина илрэхгүй
3. Тууралт нүүрнээс эхэлнэ
4. Арьс салстын бүрэн бүтэн байдал алдагдсан байна
5. Эрүүн доорхи тунгалагийн булчирхай томорно

/266./ Хүний биеийн өвөрмөц бус хамгаалах тогтолцоонд юу хамаарах вэ?

1. Арьс салстын хамгаалах урвал,
2. Лизоцим ба ходоодны хүчил
3. Амьсгалын замын намираа хучуур эд
4. Т- лимфоцит
5. Эсрэг бие

/267./ Цусан суулга өвчин нэг хүртлэх насны хүүхдэд ямар онцлогтой илэрдэг вэ?

1. Өтгөн ус ихтэй, усгүйжилтэнд амархан орно
2. Өтгөн салс ихтэй
3. Бүдүүн гэдэсний үрэвслийн шинж бүдэг илэрсэн
4. Дисбактериоз болох нь амархан
5. Бөгсний амсар онгойно

/268./ Архаг гепатит, элэгний цирроз улмаар хавдар үүсгэдэг вирусүүдийг тэмдэглэ

1. Гепатитын D вирус

2. Гепатитын В вирус
3. Гепатитын С вирус
4. Гепатитын А вирус
5. Гепатитын Е вирус

/269./ Парагриппийн халдварын үеийн эмнэлзүйн шинжүүдийг тэмдэглэ.

1. Бүх булчингаар өвдөх
2. Толгой өвдөх
3. Нүдний алим өвдөх
4. Хоолой сөөх
5. Шингэн нус их гоожих

/270./ Менингококцемийн үед илрэх өвөрмөц шинжийг нэрлэ

1. Толгой хүчтэй өвдөх
2. Цусархаг тууралт гарах
3. Олон удаа бөөлжих
4. Гэнэт өндөр халуурах
5. Ухаан алдах

/271./ Улаан эсэргэний тууралтын үндсэн шинжийг сонго.

1. Том толбот гүвдрүүн тууралт
2. Жижиг цэгэн улаан тууралт
3. Цэврүүт тууралт
4. Загатнана
5. Арьсны өнгө хэвийн

/272./ Герпес вирусийн халдварыг дараахь байдлаар ангилдаг:

1. Анхдагч
2. Дахилтат
3. Түгмэл хэлбэр
4. Байршмал хэлбэр
5. Хавсарсан герпес

/273./ Цочмог цусан суулгын үед эмгэг анатомын ямар өөрчлөлт гарч болох вэ?

1. Салст бүрхүүл улайж үрэвссэн
2. Фибринт өнгөр
3. Шархлаа үүссэн
4. Салст бүрхүүл үхэжсэн, цоорсон
5. Цус алдсан байна

/274./ Менингоккийн мэнэнгийн үед нугасны усанд зонхилон илрэх өөрчлөлтүүдийг тэмдэглэ.

1. Даралт ихсэх
2. Булингартай болох
3. Уураг нэмэгдэх
4. Эсийн тоо цөөрөх
5. Тунгалаг эс зонхилон нэмэгдэх

/275./ Бруцеллез өвчний эмгэг жамын үе шатууд

1. Тунгалагаар зөөгдөх
2. Цусны урсгалаар зөөгдөх
3. Олон голомтот халдвар үүсгэх
4. Голомтоос нян дахин цусанд эргэх
5. Дархлаа тогтож, эдгэрэх

/276./ Урвах тахлын эгэл бус хэлбэрүүдийг тэмдэглэ.

1. Өндөр настай хүмүүст
2. Хуурай хэлбэр
3. Жирэмсэн эмэгтэйд
4. Цахилгаан хэлбэр
5. Бага насны хүүхдэд

/277./ Халдвар хордлогын шокийн үед дараах биологийн идэвхит бодисуудаас аль нь ялгардаггүй вэ?

1. Катехоламин
2. Серотонин

3. Тромбопластин
4. Аденилциклаза
5. Гистамин

/278./ Архаг В гепатитын эмчилгээнд зайлшгүй шаардлагатай эмчилгээний аргыг сонгоно уу?

1. Эссенциале форте 2 калсул өдөрт 3 удаа 2 сар уух
2. Интерферон схемээр тарих
3. Легалон 90 мг өдөрт 3 удаа уух
4. Ламивудин 100 мг өдөрт 1 удаа уух
5. Витамин .С. 5% - 2.0 + Глюкозын хамт тарих

/279./ Аденовируст халдвар эмнэл зүйн ямар хэлбэрүүдээр явагдах вэ?

1. Конъюктивит
2. Фарингит
3. Кератит
4. Колит
5. Менингит

/280./ Халдвартын больницын тасаг ямар зохион байгуулалттай вэ?

1. Ердийн палат
2. Боксын
3. Боксын бус
4. Хагас боксын
5. Төлбөртэй

/281./ Иерсиниозын халдварыг тараах эх уурхай юу вэ?

1. Хулганы төрлийн мэрэгчид
2. Гэршсэн мэрэгчид
3. Шувууд
4. Гэрийн тэжээмэл амьтад
5. Хүмүүс

/282./ Гепатитын В вирусийн халдварыг дамжуулж болох хүчин зүйлийг тэмдэглэ.

1. Цус
2. Зүү тариур
3. Үрийн шингэн
4. Бохир гар
5. Ахуйн хавьтал

/283./ РС вируст халдварын эхэн үед эмнэлзүйн ямар шинжүүд гарах вэ?

1. Ханиах
2. Булчингаар өвдөх
3. Өндөр халуурах
4. Толгой өвдөх
5. Цэр гарах

/284./ Тархины цочмог хаван үүссэх үндсэн шалтгаан нь:

1. Тархины цусан хангамжийн хямрал
2. Нугасны усны хөдөлгөөн алдагдах
3. Тархины эдийн хүчилтөрөгчийн дутал
4. Тархины хордлого
5. Тархины бодисын солилцооны хямрал

/285./ Ёлом өвчний эмнэл зүйн ангилалд хамаатай асуудлыг доорхи хариултаас тохируулан сонго.

1. Эритематоз хэлбэр
2. Эритематоз – буллез
3. Буллез – цусархаг
4. Шархлаат
5. Фибринт өнгөрт

/286./ Герпес вирус нь:

1. РНХ агуулсан
2. ДНХ агуулсан
3. Эсийн гадна өсөж үрждэг

4. Липид уургийн бүрхүүлтэй,
 5. Зөвхөн амьсгалын замаар халдварладаг
- /287./ Цочмог цусан суулгын колитын хэлбэрийн үед ямар шинжүүд илрэх вэ?
1. Өвчний эхлэл хурц
 2. Хий дүлнэ
 3. Хэвлийн доод хэсгээр базалж өвдөнө
 4. Ус ихтэй суулгана
 5. Маш их хөстэй
- /288./ Урвах тахлын эгэл бус хэлбэрүүдийг тэмдэглэ.
1. Өндөр настай хүмүүст
 2. Хуурай хэлбэр
 3. Жирэмсэн эмэгтэйд
 4. Цахилгаан хэлбэр
 5. Бага насны хүүхдэд
- /289./ Гахайн хавдрын үед төмсөг хавдсан үед ямар эмчилгээ хийх вэ?
1. Хүйтэн жин тавих
 2. КС гормон
 3. Сойж боох
 4. УВЧ
 5. Бүлээн жин
- /290./ Урвах тахал өвчний баасны шинж чанарыг тэмдэглэ.
1. Усархаг
 2. Хэмжээ их
 3. Үнэргүй
 4. Цусны судалтай
 5. Хоолны үлдэцтэй
- /291./ Халдвар хордлогын шокийн үед арьсан дээр гарах тууралт:
1. Цөөн тооны гүвдрүүт
 2. Олон тооны жижиг үхжилттэй цусархаг
 3. Цөөн тооны цусархаг
 4. Том том цөөн тооны үхжилттэй цусархаг
 5. Олон тооны цэврүүт
- /292./ Бруцеллезтэй өвчтөнг хэдийд халуун шавар, рашаан, сувилалд явуулж болох вэ?
1. Цочмог хэлбэр
 2. Үлдэц хууч
 3. Архаг үрэвсэл сэдэрсэн
 4. Архаг үрэвсэл намдсан
 5. Аль ч үед болно
- /293./ Улаан эсэргэнэ өвчний үед арьсан дээр ямар өөрчлөлт илрэх вэ?
1. Цэгчилсэн толбо-гүвдрүү гарна.
 2. Гуужилт
 3. Арьсны зураглал цагаан
 4. Арьс чийглэг
 5. Мөчдийн үзүүр хүйтэн
- /294./ Элэгний цочмог энцефалопатийг эмчлэхэд зайлшгүй чухал эмчилгээний аргуудыг сонго.
1. Тархины хаванг бууруулах
 2. Ходоод гэдсийг цэвэршүүлэх
 3. Уургийн задралыг саатуулагч ферментүүдийг тарих
 4. Хүчилтөрөгч амьсгалуулах
 5. Хордлого тайлах
- /295./ Бичил биетнийг эмгэг төрүүлэгч чадвараар нь хэдэн бүлэгт хуваадаг вэ?
1. Эмгэг төрүүлэгч,
 2. Эмгэг бус төрүүлэгч,
 3. Болзолт эмгэг төрүүлэгч
 4. Нян
 5. Вирус

/296./ Бруцеллезийн халдвар дамжих замуудыг сонго

1. Ахуйн хавьтал
2. Агаар тоос
3. Хоол боловсруулах
4. Шавьж, мэрэгчид
5. Цусаар

/297./ В гепатитын үүсгэгчийн эсрэг төрөгчдийг тэмдэглэнэ үү?

1. HBsAg
2. HBcAg
3. HBe Ag
4. HA-Ag
5. HDcAg

/298./ Халдвар хордлогын шок үүсэж буй гол механизм нь:

1. Бодисын солилцооны гаралтай хүчилшил,
2. Судсан дотор цус түгэн бүлэгнэх хамшинж
3. Эд эсийн хүчилтөрөгчийн дутал
4. ТМТ-ы хордлого
5. Бичил эргэлтийн хямрал

/299./ Халдварт мононуклеозын үед илрэх гол шинж тэмдгүүд:

1. Халуурах
2. Лимфаденит
3. Ангина
4. Тууралт
5. Суулгалт

/300./ Ямар хүчин зүйлүүдийн дутагдал нь гемофили А,В өвчний шалтгаан болох вэ?

1. VII хүчин зүйл
2. VIII хүчин зүйл
3. X хүчин зүйл
4. IX хүчин зүйл
5. XI хүчин зүйл

/301./ Лабораторийн ажлын ширээн дээр тогтмол байх зүйлсийг нэрлэ.

1. Халдваргүйжүүлэгч уусмал
2. Бактерийн зүү
3. Микроскоп
4. Грамын будаг
5. Нэг удаагийн бээлий

/302./ Организмд уургийн биологийн үүрэг юу вэ ?

1. Нөхөн төлжүүлэх ба осмос даралтыг тохируулах
2. Зөвхөн энергийн
3. Фермент ба гормоны
4. Цусны биелэг чанарыг барьж байх
5. Удамшил дамжуулах

/303./ Халдварт өвчний үүсгэгч илрүүлэх ПГУ-ын шинжилгээний үед шинжлэгдэхүүн бохирдохоос сэргийлж мөрдөх шаардлагууд

1. Шинжлэгдэхүүнээс РНХ ялгах орчиныг ПГУ-ын шинжилгээний өрөөнөөс тусдаа зохион байгуулах /*/

2. ПГУ-ын мастер холимогийг тусгай цэвэр өрөөнд бэлдэх ёстой

3. Өрөөнүүдэд байрлуулсан тоног төхөөрөмж, лабораторийн хэрэгсэл тус тусдаа байх бөгөөд өөр хооронд нь дамжуулж хэрэглэхийг хориглоно

4. Шинжилгээ бүрт нэг удаагийн бээлий өмсөх ёстой

5. Урвалж болон шинжлэгдэхүүн бүхий савыг аль болох (хурдан) таглаж, зөв хадгалах

/304./ Лейкоцитуудын биемахбодийн дархлалын урвалд гүйцэтгэх үүргүүдийг нэрлэнэ үү?

1. Фагоцитоз хийх
2. Хорыг задлан хоргүйжүүлэх
3. Эсийн ба шингэний дархлааг үүсгэх
4. Гистамин ба гепарины солилцоонд оролцох

5. Эсрэгбие үүсгэх
- /305./ Нүүрс усны боловсруулалтанд оролцдог ферментийг нэрлэнэ үү?
1. Пепсин
 2. Амилаза, сахараза
 3. Трипсин
 4. Мальтаза, лактаза
 5. Липаза
- /306./ Бөөрний нефроны бүтцэнд ордог зүйлүүдийг нэрлэнэ үү?
1. Судсан түүдэг
 2. Түүдгийн бүрээс
 3. Бөөрний сувганцрууд
 4. Аяганцар
 5. Тэвшинцэр
- /307./ Тэмбүү үүсгэгч илрүүлэх шинжилгээний сорьцууд
1. Цагаан эс
 2. Ийлдэс
 3. Наалдац
 4. Арчдас
 5. Шээс
- /308./ Вакутайнерын систем нь ямар иж бүрдлүүдээс тогтох вэ ?
1. Зүү баригч
 2. Вакутайнерын хуруу шил
 3. Зүү
 4. Өндөг цоологч
 5. Хуруу шил
- /309./ Сүрьеэгийн нян илрүүлэх микробиологийн шинжилгээний аргуудыг нэрлэнэ үү?
1. Хэвлийн шингэнд нян өсгөвөрлөх
 2. Үнхэлцэг хальсны шингэнд нян өсгөвөрлөх
 3. Гялтан хальсны шингэнд нян өсгөвөрлөх
 4. Идээнд нян өсгөвөрлөх
 5. Хүчилд тэсвэртэй нян илрүүлэх
- /310./ Рубивирус жирэмсэн үед эхээс урагт дамжин халдварлахад илрэх эмгэг өөрчлөлтийг тодорхойл.
1. Генетикийн гажиг өөрчлөлтүүд
 2. Дотор эрхтний эмгэг өөрчлөлтүүд
 3. Үе мөчний эмгэг өөрчлөлтүүд
 4. Улаануудын төрөлх хам шинж (Congenital ubella Syndrom)
 5. Түнхний мултрал
- /311./ Амилаза фермент ямар булчирхайнаас шүүрлээ илүү гаргадаг вэ ?
1. Бамбай булчирхай
 2. Ходоодны доод булчирхай
 3. Нойр булчирхай
 4. Шүлсний булчирхай
 5. Гипофиз
- /312./ Нугасны шингэнд цитоз тоолохын тулд ямар шингэнүүдийг хэрэглэх вэ?
1. 3% цууны уусмал
 2. 10% цууны хүчил
 3. 0.9% хлорт натрийн уусмал
 4. Самсоны урвалж
 5. 5% хлорт кальцийн уусмал
- /313./ Цусны шинжилгээний үзүүлэлтүүдийн өөрчлөлтийг заана уу?
1. Эритроцит 4,1 сая
 2. Савхан бөөмт 10%
 3. Гемоглобин 120 г/л
 4. ЭТХ 22 мм/цаг
 5. Лейкоцит 8000

/314./ Хүний биеийн хэвийн бичилбиетэн ихтэй эрхтэнг нэрлэ.

1. Арьс
2. Бүдүүн шулуун гэдэс
3. Хэвлийн хөндий
4. Чих хамар хоолой
5. Давсаг

/315./ Humalyzer junior багаж нь үйл ажиллагааны ямар зарчмуудтай вэ ?

1. Шинжилгээ хийх
2. Шинжилгээний арга зүйг программчлах
3. Ажлын горимд оруулах
4. Багажийн зөв эсэхийг хянах
5. Инкубаци хийх

/316./ Пневмококкын эсийн бүтэц болон зарим онцлог шинжийг тэмдэглэ

1. Грамын аргаар эерэг будагдана
2. Ланцет хэлбэрийн хос кокк
3. Ихэнх тохиолдолд капсулгүй
4. Зарим үед капсултай болдог
5. Пептидогликанд нь тейхийн хүчил агуулагдана

/317./ Витамин В12 ба фолийн хүчил дутагдах шалтгаануудыг нэрлэнэ үү?

1. Хоол хүнсэнд дутагдах
2. Гастромукопротейны дутагдлын үед
3. Туяаны өвчин
4. Фолийн хүчлийн антогонист эмийн бодис ихээр хэрэглэсэн үед
5. Биемахбодид дээрх бодисын хэрэгцээ ихсэх

/318./ Өөх тос, тосонцор бодисын биологийн үүргүүдийг нэрлэнэ үү ?

1. Бүтцийн ба энергийн, дулааны
2. Зөөврийн
3. Механик ба цийдмэгжүүлэх, уусгах
4. Дааврын ба аминдэмийн
5. Тусгаарлах ба хамгаалах

/319./ Бөөрний органик гэмтлээс болсон уураг гаралт нь ямар өвчнүүдийн үед илрэх вэ?

1. Нефроз хам шинж
2. Хурц нефрит
3. Архаг нефрит
4. Нефросклероз
5. Бөөрний сүрьеэ

/320./ Уургийн молекул дахь химийн холбоонуудыг нэрлэ?

1. Пептидийн холбоо
2. Цах. статистик хүч
3. Устөрөгчийн холбоо
4. Ионы холбоо
5. Дисульфидийн холбоо

/321./ Захын цусанд байдаг цагаан эсүүдийг заана уу?

1. Миелоцит
2. Эозинофил
3. Метамиелоцит
4. Моноцит
5. Пролимфоцит

/322./ Гипогликеми болох тохиолдлууд аль нь вэ?

1. Хүнс тэжээлийн нүүрс усны хангамж муугаас
2. Шээсээр глюкоз их ялгарснаас
3. Гликогений хуримтлал хэт ихэссэнээс
4. Инсулины ялгаралт хэт ихэссэнээс
5. Бамбай, бөөрний дээд булчирхай, өнчин тархины дааврын ялгаралт багассанаас

/323./ ASAT ферментийн идэвхжил ихсэх нь ямар өвчнүүдийн үед их байх вэ ?

1. Зүрхний шигдээс

2. Механик шар
 3. Хурц ба архаг шар
 4. Булчингийн тэжээлийн доройтол
 5. Үсэрхийлсэн элэгний хатуурал
- /324./ Эритроцитын хэвийнбус агуулагдахуунуудыг заана уу?
1. Базофильный пунктаци
 2. Жоллийн биес
 3. Кольцо Кебота
 4. Хорт мөхлөгүүд
 5. Эсэд хөндий үүсэх
- /325./ Цус багадалтыг өнгө илтгэгчээр нь хэрхэн ангилах вэ?
1. Гипохромын
 2. Нормохромын
 3. Гиперхромын
 4. Микроцитын
 5. Макроцитын
- /326./ Цус бүлэгнэлтийн тогтолцооны гол хүчин зүйлүүдийг нэрлэнэ үү?
1. Судас
 2. Ялтаст эс
 3. Сийвэнгийн хүчин зүйлүүд
 4. Улаан эс
 5. Цагаан эс
- /327./ Шилжвэр хучуур эсэд ямар хучуур эсүүд багтах вэ?
1. Дугуй
 2. Гонзгой
 3. Сүүлтэй
 4. Хавтгай
 5. Бөөрний
- /328./ Reflotron нь багаж нь ямар иж бүрлүүдээс тогтох вэ ?
1. Reflotron тест
 2. Хяналтын тууз
 3. Пипетик
 4. Суурь
 5. Цэвэрлэгч төхөөрөмж
- /329./ Тархи нугасны шингэнд цитоз эрс өндөрсөх нь ямар өвчний үед байх вэ?
1. Сүрьеэгийн менингит
 2. Тархи нугасны гаралтай хавдар
 3. Серозон менингит
 4. Тархи нугасны гэмтэл
 5. Мэс заслын дараа
- /330./ Сүүлийн жилүүдэд манай орны эмнэлгийн лабораторийн шинжилгээнд нэвтэрч байгаа шинэ багаж, тоног төхөөрөмжүүдийг заана уу ?
1. Humalyzer junior, Humalyzer – 2000
 2. Celltak , Elisa reader
 3. Reflotron , Combina
 4. HumacLOT , Humacheck
 5. Гематологийн анализатор
- /331./ Давсагны үүргийг заана уу?
1. Шээсийг үүсгэх
 2. Шээсийг цуглуулж хадгалах
 3. Шээсийг эргэх шимэх
 4. Шээсийг үе үе хөөж гаргах
 5. Хүчил, шүлтийн тэнцвэрийг зохицуулах
- /332./ Өвчтөнөөс бактериологийн шинжлэгдэхүүнийг ямар үед авах ёстой вэ?
1. Антибиотик эмчилгээ эхлэнгүүт
 2. Антибиотик эмчилгээний явц дунд

3. Антибиотик эмчилгээ эхэлсэн бол 8-10 цагийн дараа
 4. Антибиотик эмчилгээ эхлээгүй байхад
 5. Антибиотик эмчилгээ эхэлсэнээс 2-3 цагийн дараа
- /333./ Нэрлэсэн вирус хоол боловсруулах замаар дамжин халддаг
1. TTV
 2. HAV
 3. HCV
 4. HEV
 5. HBV
- /334./ Хоолойн арчдаст нян, вирус өсгөвөрлөх шинжилгээ хийх өвчнүүдийг нэрлэнэ үү
1. Заг хүйтэн
 2. Ангина
 3. Томуу
 4. Дизентерия
 5. Хоолны хордлогот халдвар
- /335./ Дурьдсан тохиолдолуудад HCV, HBV-ын халдвар авах эрсдэлтэй
1. Олон хүнтэй бэлгийн харьцаанд байх
 2. Мансууруулах бодис судсаар тарьж хэрэглэдэг
 3. Зүү тариур буцалгаж хэрэглэх
 4. Мэс ажилбарууд
 5. Цус, цусан бүтээгдэхүүн байнга хэрэглэдэг хүмүүс
- /336./ Өвчтөнөөс авсан шинжлэгдэхүүнд пневмококк илрүүлэхийн тулд шинжлэгдэхүүнийг хадгалах, тээвэрлэхэд юу анхаарах шаардлагатай вэ
1. Шинжилгээг 2 цагийн дотор хийнэ
 2. Шинжлэгдэхүүнийг +35°C-д хадгална.
 3. Хүчиллэг орчинд байлгах юмуу хатааж болохгүй
 4. Хөргөгчид хадгална
 5. Шинжилгээг 72 цагийн дараа хийнэ
- /337./ Амьсгалах байдлаар нь бичилбиетнийг хэрхэн ангилах вэ?
1. Сапрофитууд
 2. Аэробууд
 3. Анаэробууд
 4. Туйлбаргүй агааргүйтэн
 5. Туйлбаргүй агаартан
- /338./ Шувууны томуугийн вирусийн хүний өвчлөлийн үед вирус илрүүлэх шинжилгээнд ямар сорьц авах вэ
1. Хамрын арчдас
 2. Залгиурын арчдас
 3. Уушиг, бронхын эд
 4. Цус
 5. Хос ийлдэс
- /339./ Ямар өвчний үед цусан дахь нийт уургийн хэмжээ багасдаг вэ ?
1. Халдварт шар, элэгний хатуурал
 2. Бөөрний өвчнүүд
 3. Хорт хавдар, сүрьеэ
 4. Гемолиз шар
 5. Гэдэсний түгжрэл
- /340./ Сүрьеэгийн савханцрын эсийн бүтцийн онцлогийг тодорхойл
1. Грамын аргаар эерэг будагдана
 2. Циль-Нельсеней аргаар сайн будагдана
 3. 60%-ийн липид агуулсан пептидо-гликантай
 4. Эсийн ханын липид нь 60-90 атом бүхий нүүрсуснаас тогтсон миколын хүчилтэй
 5. Гликолипид, гликопептид (мукосайд) агуулна
- /341./ ASAT ферментийг хамгийн их агуулдаг эрхтэнүүдийг заана уу?
1. Зүрх
 2. Элэг

3. Биеийн булчингууд
 4. Бөөр
 5. Нойр булчирхай
- /342./ Гемоглобины ихэсдэг эмгэгүүдийг заана уу?
1. Далд цус алдалт
 2. Уушиг- зүрхний дутагдал
 3. Хорт хавдар
 4. Зүрхний төрөлхийн гажиг
 5. Ясны хэмийн гэмтэл
- /343./ Сахарын ачаалалт сорилын зорилгыг нэрлэнэ үү?
1. Нүүрс усны солилцоог судлах, хянах
 2. Нойр булчирхайн дааврын үйл ажиллагааг судлах
 3. Гипер ба гипогликемийн коэффициентуудыг бодож гаргах
 4. Чихрийн шижин өвчний үеийн гликемийн тахирмагийг гаргах
 5. Глюкозурийн зураглал гаргах
- /344./ Хүний улаан эсийн дотор доорх эсрэгтөрөгч, эсрэгбиеийн аль байх вэ?
1. А эсрэгтөрөгч
 2. В эсрэгтөрөгч
 3. Rh эсрэгтөрөгч
 4. Альфа-эсрэгбие
 5. Ветта-эсрэгбие
- /345./ Ферментэн урвалын хурдад нөлөөлдөг хүчин зүйлүүдийг нэрлэ
1. Орчны температур
 2. Орчны PH
 3. Субстратын хэмжээ
 4. Кофакторуудын хангамж
 5. Орчны усны хэмжээ
- /346./ Давсагны үрэвслийн үед шээсний тундсанд ямар элементүүд давамгайлж илрэх вэ?
1. Гонзгой хучуур эс
 2. Дугуй хучуур эс
 3. Хавтгай хучуур эс
 4. Лейкоцит
 5. Цилиндр
- /347./ Цэрэнд илэрдэг элементүүдийг заана уу?
1. Шарко – Лейдений талст
 2. Лейкоцит
 3. Куршманы утаслаг
 4. Эритроцит
 5. Бортгон хучуур эс
- /348./ Цус төлжилтийн хөгжлийн V шатны эсүүдийг нэрлэнэ үү?
1. Нормоцит оксифильный
 2. Ретикулоцит
 3. Метамиелоцит
 4. Савхан бөөмт эс
 5. Мегакариоцит
- /349./ Хэсэгчилсэн аргаар ходоодны шүүсийг авах шинжилгээний үе шатуудыг нэрлэнэ үү?
1. Өлөн үеийн шүүс авах
 2. Суурь шүүрлийг авах
 3. Цочроогчийн дараах шүүрлийг авах
 4. Үлдэгдэл шүүрлийг авах
 5. Нийт шүүрлийг авах
- /350./ Сувганцрын эсээр идэвхгүй эргэж шимэгдэлтээр ямар бодисууд эргэн шимэгдэх вэ?
1. Ус
 2. Глюкоз
 3. Хлорт давс
 4. Нүүрсхүчлийн хий

5. Мочевин

/351./ Бичил амь судлалын лабораторийн өрөөнүүдийг нэрлэ.

1. Тэжээлт орчны
2. Хувцас солих
3. Ариутгалын
4. Бокс
5. Сорьц хүлээж авах

/352./ Суулгалт өвчин үүсгэгчийн халдвар дамжилтыг тодорхойл

1. Бохирлогдсон ус, хүнсний бүтээгдэхүүнээр
2. фекал-орал буюу өтгөн- мөрийн замаар
3. Дутуу боловсруулсан хүнсний бүтээгдэхүүнээр
4. Аэробактин нийлэгжүүлэх плазмид агуулж байвал эмнэлгийн дотор халдварын үндсэн шалтгаан болно
5. Бохир зүү тариураар

/353./ Reflotron багаж нь клиник химийн үзүүлэлтүүдийг биологийн ямар шингэнд тодорхойлдог вэ ?

1. Цусанд
2. Ийлдсэнд
3. Сийвэнд
4. Нугасны усанд
5. Шээсэнд

/354./ Хөөмийн арчдаст нян өсгөвөрлөх шинжилгээг ямар халдварын үед хийх вэ

1. Гепатит
2. Суулгалтат халдвар
3. Дох
4. Сахуу
5. Шархны халдвар

/355./ Архаг халдвар үүсгэдэг РНК агуулсан вирусн нэрлэнэ үү.

1. Гепатит С
2. Томуу
3. ХДХВ
4. Улаанбурхан
5. Салхин цэцэг

/356./ Эмгэгтөрүүлэгч диплококк аль нь вэ?

1. Гонококк
2. Менингококк
3. Пневмококк
4. Стафилококк
5. Стрептококк

/357./ Бичилбиетний үндсэн хэлбэрийг нэрлэ

1. Савханцар
2. Кокк
3. Мушгиа
4. Тахир
5. Утаслаг

/358./ Пневмококкоор халдвар авсны дараа өвчний цочмог үед өвчтөний ийлдсэнд ямар өвөрмөц уураг тодорхойлогдох вэ?

1. Трансфераза
2. Альбумин
3. Оксиредуктаза
4. Бетта-глобулин (С-реактив-протеин-CRP)
5. Оксидаза

/359./ Сүрьеэгийн савханцарын онцлог шинж чанарыг тэмдэглэ

1. Тэжээлт орчинд хурдан өсч үржинэ.
2. Хүчилтөрөгчтэй орчинд өсч үржинэ (аэроб)

3. Аналины будгаар сайн будагдана
 4. Хүчилд тэсвэртэй савханцар
 5. Ариутгалын бодист амархан тэсвэржинэ
- /360./ Цусны ийлдсэн дэх ALAT ихсэх нь ямар өвчний үед их тохиолдох вэ ?
1. Хурц шар
 2. Механик шар
 3. Элэгний хатуурал
 4. Зүрхний шигдээс
 5. Элэгний хордлогот үхжил
- /361./ Нүүрс усны өөрчлөлтийг судлахшинжилгээнд ямар сорьц авах вэ?
1. Цус
 2. Нугасны ус
 3. Шээс
 4. Шүлс
 5. Ходоодны шүүс
- /362./ Цэсний пигментэд билирубины ямар бүтээгдэхүүнүүд орох вэ ?
1. Нийт билирубин
 2. Уробилин ба уробилиноген
 3. Шууд билирубин ба холбоот
 4. Стеркобилин ба стеркобилиноген
 5. Шууд биш билирубин ба чөлөөт билирубин
- /363./ Лейкоцитури ямар өвчнүүдийн үед давамгайлрэх вэ?
1. Нефрит
 2. Цистит
 3. Бөөрний хавдар
 4. Пиелонефрит
 5. Чихрийн шижин
- /364./ Вит В12 ба фолийн хүчил дутагдлын цус багадалтын үед лабораторийн шинжилгээгээр ямар өөрчлөлт илрэх вэ?
1. Нв-ы хэмжээ бага зэрэг буурна
 2. Эр-ын тоо эрс цөөрнө
 3. Өнгө илтгэгч ихэсч гиперхроми илэрнэ
 4. Эр-ын голч ихэснэ, мегалоцит, макроцит илэрнэ
 5. Анизоцит, пойкилоцит илэрнэ
- /365./ Гемоглобины агууламж багасдаг эмгэгүүдийг заана уу?
1. Цус багадалт
 2. Цочмог цус алдалт
 3. Далд цус алдалт
 4. Хорт хавдар
 5. Ясны хэмийн гэмтэл
- /366./ Түүдгэнцрийн шүүрэх процесст саад болж байдаг даралтуудыг нэрлэнэ үү?
1. Хялгасан судасны гидростатик даралт
 2. Сийвэнгийн уургийн даралт
 3. Гол судасны даралт
 4. Бөөрний дотоод даралт
 5. Хэвлийн хөндийн даралт
- /367./ Elisa аппаратаар ямар шинжилгээнүүдийг хийдэг вэ?
1. Гепатитын маркер
 2. ДОХ-ын вирус
 3. Бамбай булчирхайн гормон
 4. Хеликобактер
 5. Ig G, M, A
- /368./ Зимницкийн сорилыг ямар үзүүлэлтээр дүгнэх вэ?
1. Өдөр шөнийн шээсний харьцаа
 2. 8 удаагийн шээсний хувийн жин
 3. Хоногийн шээсний хэмжээ

4. Шээсний урвал
 5. Шээсний өнгө
- /369./ Бэлгийн замын халдвар үүсгэдэг диплококк аль нь вэ?
1. Менингококк
 2. Пневмококк
 3. Стафилококк
 4. Гонококк
 5. Стрептококк
- /370./ Humalyzer-2000 аппарат нь ямар аргуудаар шинжилгээний программчлал хийдэг вэ?
1. Standart mode
 2. Rafe mode
 3. Factor mode
 4. Absorvents mode
 5. Multi point mode
- /371./ Бруцеллэз өвчин үүсгэгчийн халдвар дамжих замыг тодорхойл.
1. Усаар дамжин халдварлана
 2. Бохир зүү тариураар халдварлана
 3. Амьсгалын замаар халдварлана
 4. Арьс салстын гэмтлээр дамжин халдварлана
 5. Бэлгийн замаар
- /372./ ДОХ өвчин үүсгэдэг вирусн нэршил, төрөл зүйлийг тодорхойл
1. HTLV
 2. LTV
 3. Лентивирусын төрөл
 4. HIV 1, HIV 2
 5. Ареновирусын төрөл
- /373./ Пневмококкт халдварыг оношлоход түгээмэл хэрэглэдэг аргуудыг тэмдэглэ.
1. Цэр, цуснаас өсгөвөр бэлтгэх
 2. Цэрийг шууд микроскопоор шинжих
 3. Оптокин сорил тавих
 4. Ийлдэст наалдуулах урвал
 5. Хавсрага холбох урвалын арга
- /374./ Менингококк (*Neisseria meningitidis*)-ийн бактер судлалын онцлогийг тайлбарла.
1. Менингококк нь хосоор байрладаг. (Диплококк)
 2. Грам сөрөг, дулааны хэлбэлзлэл болон хатаахад тэсвэргүй
 3. Эсийн хананд нь липоолигосахарид (LOS) агуулагдана
 4. Пили болон адгези идэвхт гадаргуугын хоёр төрлийн молекултай (Ора, Орс)
 5. Хоолойн арчдас, нугасны усанд илрүүлэх боломжтой
- /375./ Хүчиллэг мукополисахаридуудын гол төлөөлөгчдийг сонгоно уу ?
1. Гиалуроны хүчил
 2. Гепарин
 3. Хондроитин хүхрийн хүчил
 4. Пектин, гуммин
 5. Агар
- /376./ Аль нь бэлгийн замын халдварт өвчин үүсгэх вэ
1. *Neisseria gonorrhoeae*
 2. *Trichomoniasis*
 3. *Gardnerella vaginalis*
 4. *Herpes simplex virus*
 5. *Ureaplasma*
- /377./ Билирубин хаана үүсдэг вэ ?
1. Ретикулоэндотелийн системд
 2. Гемоглобины задралаас
 3. Миоглобины задралын үед
 4. Цэсэнд цэсний хүчлийн задралаас
 5. Ходоодонд давсны хүчлийн нөлөөгөөр

/378./ Үл орлогдох өөх тосонд ямар өөх тос орох вэ?

1. Байгалийн жинхэнэ өөх тос
2. Тосонд уусдаг витаминууд агуулсан өөх тос
3. Тосны ханаагүй хүчлүүд агуулсан өөх тос
4. Тосны ханасан хүчлүүд агуулсан өөх тос
5. Үүсмэл өөх тос

/379./ ЭТХ ямар өвчнүүдийн үед түргэсэх вэ?

1. Хүнд хэлбэрийн чихрийн шижин
2. Тиреотоксикоз
3. Хурц лейкоз
4. Хорт хавдарын задрал
5. Цус багадалт

/380./ Хүний амьдралын явцад байдаг хэвийн гемоглобины хэлбэрүүдийг нэрлэнэ үү?

1. Hb A1
2. Hb A2
3. Hb F
4. Hb C
5. HbS

/381./ Боумен Шумлянскийн бүрээсэнд түүдгийн судсуудаар урсаж байгаа цусны ямар хэсгүүд шүүрэх вэ?

1. Уураг
2. Ус
3. Эритроцит
4. Сийвэнгийн бага молекулт бүрэлдэхүүн
5. Том молекулт бүрэлдэхүүн

/382./ Шээс үүсэх үе шатыг нэрлэнэ үү?

1. Түүдгийн шүүрэх
2. Сувганцарын эргэж шимэгдэх
3. Гадагш ялгарах
4. Уусан шингэн бөөрөнд цэвэрлэгдэх
5. Салстаар ялгарах

/383./ Цусны бүлэгнэлийн шинжилгээнээс Hemaclot багажаар ямар үзүүлэлтүүдийг тодорхойлдог вэ?

1. Тромбины хугацаа
2. Протромбины хугацаа
3. Идэвхтэй тромбо тестын хугацаа
4. Фибриногены хэмжээ
5. 13-р хүчин зүйл

/384./ Шээсээр сахар гарах эмгэг шалтгаануудыг заана уу?

1. Инсулин гормон дутагдах үед
2. Элэг, мэдрэлийн системийн эмгэгийн үед
3. Бөөрний системийн эмгэгийн үед
4. Цусны эргэлтийн дутагдлын үед
5. Амьсгалын системийн эмгэгийн үед

/385./ Грамын аргаар будахад орох уусмалуудыг нэрлэ

1. Фуксин
2. Люголь
3. Генцианфиолет
4. PBS
5. Физиологийн уусмал

/386./ Humaalyzer- 2000 автомат анализатор нь хэмжилт хийх ямар зарчмуудтай вэ ?

1. 6 төрлийн долгионы уртад хэмжинэ
2. 37°-ст ажиллах термостаттай
3. Flowcell болон куветээр хэмжинэ
4. Вакум насосоор соруулж шинжилнэ

5. Үлдэгдлийг гадагшлуулж хадгалах савтай

/387./ ДОХ-ын вирус, халдвар авсан хүний биеийн эд эс биеийн шингэнд агуулагдах байдал, халдварлах нөхцлийг тодорхойл

1. Цус, ийлдэс, лейкоцит болон цусны бусад дүрст элементэнд агуулагдсан вирус дамжина

2. Үрийн шингэн (сперм)-д агуулагдан халдварлана

3. Үтрээний шүүрэл, ялгадсанд агуулагдан халдварлана

4. Арьсанд агуулагдан халдварлана

5. Нулимсаар дамжина

/388./ HCV-ын халдварын үед шинжлэгдэхүүнд илэрдэггүй нь . . .

1. HBcAg

2. HBeAg

3. HBsAg

4. Anti-HCV

5. HCV-RNA

/389./ Salmonella enteritidis -ийн биохимийн зарим онцлог шинжүүдийг тодорхойлох.

1. Эсийн хананы липополисахарид нь O-антиген, цөмийн полисахарид, липид А-гэсэн нэгжүүдээс бүрдэнэ

2. Фимбри нь манноз мэдрэг шинжтэй

3. Аэробактин нь төмрийн ионы агууламж багатай орчинд бактер удаан амьдрах нөхцлийг бүрдүүлнэ

4. Эд эсийг эмгэгшүүлэгч хор (SP - Salmonella Pathogeninsel) ялгаруулна. Хор нь 3 хэлбэртэй (SPI; SPII; SPIII)

5. Грам сөрөг савханцар

/390./ Вирус судлалын лабораторит мөрдөх дүрмийг доорхи хариултаас тохируулан сонго

1. Вирусийн өсгөврийг -20°C-д хадгалж болохгүй

2. Лабораторит эмнэл зүйн сорьц болон лабораторийн омогтой нэгэн зэрэг ажиллахыг хориглоно/

3. Хүн болон амьтнаас авсан сорьцыг нэг лабораторит шинжилж болохгүй

4. Вирусийн РНХ-ийг удаан хугацаагаар хадгалвал -20°C-т хадгална

5. Эсийн өсгөврийг -20°C-т хадгална

/391./ Сүрьеэгийн нянг ялган дүйх сорилуудыг нэрлэ

1. Ниацины сорил

2. Паранитробензойны сорил

3. Капило сорил

4. Оксидазын сорил

5. Туберкулины сорил

/392./ Гипохолестеринеми ямар өвчний үед тохиолдох вэ ?

1. Сүрьеэ

2. Вирусын шар

3. Цус багадалт

4. Тиреотоксикоз

5. Хордлого, халдварын үед

/393./ GGT-ферментийн идэвх ихсэх нь элэг, цөс, нойр булчирхайн өвчнүүдийн үед гардаг. Учир нь цөсний цорго бөглөрсөн, цөсний урсгал саатсан, цөс зогсонгшсон үед идэвхийн ихсэлт бүрч багасдаг.

/394./ Зүрхний булчингийн шигдээс өвчний үед ЛДГ-ын идэвхи ихсэх нь оношийн ач холбогдолтой. Учир нь 36-48 цагийн дараа дээд цэгтээ хүртэл ихэсч хэвийн түвшингээсээ 10-15 дахин нэмэгддэг.

/395./ Гипергликеми нь дотоод шүүрлийн эмгэгтэй холбоотой. Учир нь цусны сахарын хэмжээ эрс ихсэх нь нойр булчирхайн инсулины шүүрэл дутагдалтай болсноос үүсэх чихрийн шижингийн үед гарна.

- /396./ Нарийн гэдэсний ханаар моносахарууд шимэгдэж цусанд ордог. Учир нь хоол хүнсээр авсан полисахар, олигосахар, дисахарууд ходоод гэдэсний замд моносахар болтлоо задарч боловсордог
- /397./ 231. Чихрийн шижин өвчний үед шээсээр сахар тогтвортой өндөр гардаг. Учир нь цусны глюкозыг зохицуулдаг нойр булчирхайн гормон инсулины хэмжээ ихсэхэд чихрийн шижин үүснэ.
- /398./ Цочмог хэлбэрийн гепатитын үед сийвэнгийн Асат ба Алатын идэвхийн харьцаа буюу ДеРитисийн коэффициент ямагт нэгээс бага байдаг.
Учир нь энэ үзүүлэлтээр элэгний гаралтай ферментемийг зүрхнийхээс ялган оношлох боломжтой.
- /399./ ШФ-аза энзимийн идэвх нь элэг цөсний өвчнүүдийн үед ялган оношлох ач холбогдолтой. Яагаад гэвэл механик түгжрэлээс болсон шарлалтын үед, анхдагч биларний цирроз өвчний үед 10 дахин ихсэж гепатит холангитын үед идэвх нь буурдаг байна
- /400./ Лактатдегидрогеназа фермент нь сүүний хүчилийг пировиноградын хүчилд хувиргах эргэх урвалыг хурдасгадаг. Учир нь устөрөгчийн завсрын акцептоороор НАД коферментийг шаарддаг.
- /401./ Чихрийн шижин өвчний үед сахарын ачаалалт сорилд өөрчлөлт гардаггүй. Учир нь өлөн үеийн сахарын түвшин хэвийн, шээсэнд нь глюкоз илэрдэггүй.
- /402./ 234. Нефроз хам шинж, хурц, архаг нефрит, нефросклероз, бөөрний сүрьеэ зэрэг өвчнүүдийн үед шээсээр уураг ялгардаггүй. Учир нь эдгээр өвчнүүдийн үед нефрон гэмтсэний улмаас бөөрний түүдгэнцэрийн мембранаар уураг нэвтэрдэг байна./
- /403./ Инсулин эсийн мембраны ханын нэвчүүлэх чанарыг ихэсгэдэг. Учир нь гликолизийн ферментүүдийн нийлэгжилтийг идэвхжүүлэн, глюкокортикоидуудын нийлэгжилтийг саатуулдаг байна.
- /404./ Хурц нефрит өвчний үед шээс улаавтар өнгөтэй булингартай байдаг.
Учир нь шээсээр билирубин гарч байгаатай холбоотой өнгө нь улаавтар болдог.
- /405./ Гипогликемийн үед цусан дахь сахарын хэмжээ багасдаг.
Учир нь инсулин хамааралт чихрийн шижин, гипофиз ба бөөрний булчирхайн үйл ажиллагааны алдагдал, нойр булчирхайн эмгэг өвчнүүдийн үед тохиолдоно./
- /406./ ШФ-аза энзимийн идэвх цусанд буурна. Учир нь гипофосфатаземи, архаг гломерулонефрит, архаг цус багадалт, тиреотоксикоз, мөн бэлгийн бойжилтын өсөлтийн үед хүүхдэд буурна.
- /407./ Нэг буюу хэд хэдэн эдэд идэвхтэй үйлчилдэг мөн бусад эрхтэн эдэд бараг байдаггүй ферментүүд ч байна. Учир нь түрүү булчирхайд хүчиллэгфосфотаза фермент онцлог идэвхтэй ажээ.
- /408./ Бие махбодийн доторх нүүрсусны солилцооны гол үзүүлэлт нь цусны глюкоз юм. Учир нь цусны ийлдсэнд глюкоз бага байдаг.
- /409./ 233. Хар тугалганы, нүүрсхүчлийн хийн ба атропины хордлогын үед үе үе кетонури илэрнэ
Учир нь дээрх хордлогуудын үед өөх тос, нүүрс-усны солилцоо алдагдсантай холбоотой кетонури илэрнэ

/410./ Нийт ШФ-аза ферментийн идвэхийг шинжлэхдээ өвөрмөц 5 изоферментийг заавал шинжлэх ёстой. Учир нь ясны, элэгний, ихэсийн, гэдэсний, бөөрний изоферментүүд байдаг нь 2 валенттай Mg, Co, Mn –ний ионууд нь энэ ферментийн үйлчлэлийг идэвхжүүлэгчид юм.

/411./ Халдварт гепатитын шарлалтын үеийн эхний 7 хоногийн турш ЛДГ-н идэвх их байдаг. Учир нь өвчин хөнгөн буюу дунд зэргийн явцтай бол ферментийн идэвх хэвэндээ харин хоёрдогч байдлаар хорт хавдар үсэрхийлсэн үед ЛДГ-н идэвх хэвийн буюу 50% буурдаг байна.

/412./ Эсийн дотор глюкоз хүчилтөрөгчтэй, хүчилтөрөгчгүй замаар исэлдэн задарч энерги ялгаруулдаг. Учир нь нэмэгдэл пентозфосфатын зам хэрэглэдэггүй

/413./ Хоол хүнсний хамт гаднаас авсан нүүрсус боловсорч задраад голдуу глюкоз болдог. Яагаад гэвэл бусад моносахаруудч глюкозад шилжээд шимэгдэх тул цус болон бүхийл биологийн шингэнүүдэд нүүрс ус нь голдуу глюкоз байдлаар оршдог.

/414./ ЛДГ-ын идэвх багасах нь жирэмсэн эмэгтэйчүүд, нярай хүүхдэд ажиглагдана. Учир нь физиологийн онцлог тул түүнийг эмгэгийн үеийн процесстай адилтгаж болохгүй.

/415./ Шүлтлэг фосфотаза ферментийг голдуу ясны өвчнүүдийн үед шинжилдэг. Учир нь остеобластд хамгийн өндөр агууламжтай байдаг нь ясны өсөлт шф-ын хэмжээтэй холбоотой тул хүүхдийн цусны ийлдсэнд их байдаг

/416./ 230. Элэгний халдварт, хордлогот үрэвслийн үед, цэсний бичил цоргууд үрэвссэн үед, механик шарлалтын үед шээс ногоовтор туяатай, хар хүрэн өнгөтэй болдог. Учир нь элэгний халдварт, хордлогот үрэвслийн үед элэгний эс гэмтсэнээс, цэсний бичил цоргууд үрэвсэж бөглөрснөөс, механик шарлалтын үед цэсний замд саад үүсч гэдсэнд цэс орохгүй болсноос цусанд билирубин ихээр орж, улмаар шээсээр гарна.

/417./ ШФ-аза ферментийн идэвхийн хэмжээ буурах нь педжетийн өвчний гол шинж юм. Учир нь ясны хавдар /саркома/ Гошегийн өвчин /яс хайлах, Д-витамин дутагдалын сульдаа, остеомиелит зэрэг олон өвчний үед гипоферментеми илэрдэг

/418./ Дерма-д аль давхарга хамаарах вэ?

- A. Торлог
- B. Эвэрлэг
- C. Мөхлөгт
- D. Өргөст

/419./ Хавьтал харшлын дерматитийг оношилох гол арга

- A. Эмнэлзүй
- B. Арьсны эдийн шинжилгээ
- C. Иодын сорил
- D. Арьсны сорил

/420./ Гипергидроз гэж юу вэ?

- A. Тосны булчирхайн шүүрлийн ялгарал ихсэх
- B. Хөлсний булчирхайн шүүрлийн ялгарал ихсэх
- C. Хөлсний булчирхайн шүүрэл шингэрэх
- D. Хөлсний булчирхайн шүүрэл үнэртэй болох

/421./ Атопик дерматитын үед иммунологийн шинжилгээнд ямар өөрчлөлт гарах вэ?

- A. Т-лимфоцит буурна
- B. IgA буурна
- C. IgG өснө
- D. IgM буурна
- E. IgE өснө

/422./ Арьсны идээт өвчнийг нэрлэнэ үү

- A. Үү
- B. Хайрст үлд

- C. Сэвх
- D. Намарс
- E. Түүхий

/423./ Хуурай арьсны сөрөг үр дагавар юу вэ?

- A. Толигор
- B. Үрчийх хандлагатай
- C. Бохирдохдоо амархан
- D. Хэлрөмтгий

/424./ Мөөгөнцөрт өвчин ямар замаар халдварлахгүй вэ?

- A. Агаар дусал
- B. Хувцас хэрэглэл
- C. Халдвартай амьтнаас
- D. Саун, усан сан

/425./ Цэврүүтэх өвчнийг оношилод дараах шинж тэмдгийн аль нь илрэх вэ?

- A. Манту-гийн сорил
- B. Иодын сорил
- C. Никольскийн шинж
- D. Ауспицын шинж

/426./ Стивен Джонсоны хам шинж ямар өвчний үед илрэх вэ?

- A. Ягаан үлд
- B. Хайрст үлд
- C. Хавтгай улаан үлд
- D. Олон өнгөт үлд
- E. Олон хэлбэрт шүүдэст улайрал

/427./ Хяргагч үлдийн үүсгэгч

- A. Стафилакокк
- B. Стрептококк
- C. Варицелла зостер вирус
- D. Трихофитон
- E. Хачиг

/428./ Мөөгөнцөрт өвчнийг оношилоход дараах шинж голлоно

- A. Мөнгөлөг хайрстай гөвдрүү
- B. Идээт цэврүү
- C. Бэлцрүү
- D. Хайрстай дугуй хүрээтэй голомт

/429./ Арьсны дайвар эрхтэнүүд

- A. Үс, хумс
- B. Хайрс
- C. Сорви

/430./ Үсний ил хэсэгт дараах бүтцүүдээс аль нь байдаггүй вэ?

- A. Тархилаг давхарга
- B. Холтослог давхарга
- C. Хөхлөг
- D. Булцуу
- E. Ээрүүл хэлбэрийн эсүүд

/431./ Вирусын шалтгаант арьсны өвчин

- A. Энгийн хомхой
- B. Түүхий
- C. Хатиг
- D. Хавтгай улаан үлд

/432./ Хяргагч үлд юунаас халдварлах вэ?

- A. Хөрснөөс
- B. Ургамлаас
- C. Шавьжнаас
- D. Амьтнаас

/433./ Хамууны эмчилгээнд хэрэглэх эмийн бэлдмэл

- A. 6% давсны хүчлийн уусмал
 - B. 5% салицилын хүчлийн тос
 - C. 20% бензил бензоат тос
 - D. Унна крем
- /434./ Ягаан үлдийн эх толбо биеийн аль хэсэгт гарах вэ?
- A. Мөчдийн төгсгөлд
 - B. Нүүрээр
 - C. Салстад
 - D. Суганд
 - E. Их биеэр
- /435./ Хамуу ямар хэрэгслээр халдварлахгүй вэ?
- A. Цагаан хэрэглэл
 - B. Дотуур хувцас
 - C. Бээлий
 - D. Тоглоом
 - E. Аяга халбага
- /436./ Арьс ямар үйл ажиллагаа гүйцэтгэдэггүй вэ?
- A. Хамгаалах
 - B. Ялгаруулах
 - C. Дулаан зохицуулах
 - D. Мэдэрхүйн
 - E. Хортой нэгдэл үүсгэх
- /437./ Дермад ямар ширхэг байдаггүй вэ?
- A. Коллаген ширхэг
 - B. Уян ширхэг
 - C. Ретикуляр ширхэг
 - D. Гиалин ширхэг
- /438./ Арьсны анхдагч элемент
- A. Толбо
 - B. Нөсөө
 - C. Тав
 - D. Шалбархай
 - E. Ургацаг
- /439./ 19. Халдварт нялаахай (моллюск) өвчний үед ямар тууралт гарах вэ?
- A. Цэврүү
 - B. Толбо
 - C. Зангилаа
 - D. Гөвдрүү
 - E. Хайрс
- /440./ Арьсны хоёрдогч элемент
- A. Цэврүүнцэр
 - B. Хайрс
 - C. Товруу
 - D. Толбо
 - E. Идээт цэврүү
- /441./ Цусархаг толбонд аль нь хамаарахгүй вэ?
- A. Петехи
 - B. Пурпура
 - C. Экхимоз
 - D. Бэлцрүү
- /442./ Хайрст үлд өвчний үед ямар тууралт гарах вэ?
- A. Зангилаа
 - B. Хайрст гөвдрүү
 - C. Ширшил
 - D. Бэлцрүү
- /443./ Түүхий өвчний онош тавихад

- A. Товруу гарах
- B. Бэлцрүү гарах
- C. Үсэрхийлсэн идээт цэврүү
- D. Хайрс

/444./ Хумс хэд хоногт бүрэн солигдох вэ?

- A. 30 хоног
- B. 50 хоног
- C. 60 хоног
- D. 90 хоног

/445./ Арьсны өнгөн хөрсний давхаргыг нэрлэнэ үү

- A. Өргөст давхарга
- B. Хөхлөг давхарга
- C. Торлог давхарга
- D. Өөхлөг давхарга

/446./ Нянгийн гаралтай намарс голлож хаана байрлах вэ?

- A. Толгойн хуйх
- B. Нүүр
- C. Цээж
- D. Хөлийн шилбээр

/447./ Үү халдварлахгүй зам

- A. Мал амьтан
- B. Хүнээс
- C. Бохирлогдсон эд зүйл
- D. Хоол хүнс

/448./ Нярайд булчин сулруулагч харьцангуй бага шаардагдана:

1. Булчин сул хөгжилтэй
2. Булчингийн масс бага хувь эзэлдэг
3. Булчин-мэдрэлийн холбоо сайн хөгжөөгүй
4. Биеийн ерөнхий жин их
5. Бодисын солилцоо эрчимтэй

/449./ Хүүхдийн бодисын солилцооны идэвх:

1. Том хүнийхээс бага
2. 2 нас хүртлэх үед хамгийн их байна
3. Халуурах өвчний үед буурна
4. Бэлэг бойжилтын үед өснө
5. Жин нэмэх тусам идэвхижинэ

/450./ Пневмоторакс үүсэх шалтгаанд:

1. Цулцангууд урагдах
2. Цээжний ханын гэмтэл
3. Амьсгалын замын төгсгөл хэсэг ямар нэг шалтгаанаар плеврийн хөндийтэй холбогдох
4. Париетал (эрхтэн хучих) гялтан цоорох
5. Голтын эрхтэн цоорох

/451./ Гипервентиляцын нөлөө:

1. Таталт болох
2. Тархины судас тэлэх
3. Зүрхний түрэлт (output) буурах
4. Оксигемоглобины муруй баруун тийш хэлбийх
5. Артерийн цусны нүүрсхүчлийн хий ихсэх

/452./ Дараах шингэнүүдийн аль нь коллоид шингэн бэ?

1. 5% альбумин
2. 5% декстроз (глюкоз)
3. 6% гетстарч
4. 7.5% хлорт натри
5. 10% хлорт натри

/453./ Толгой нь өвддөг ухаангүй өвчтөнд ГДД хянах монитор тавьжээ. Хүчилтөрөгч, N2O өгснөөр ГДД ихэссэн байна. Ямар эм ГДД-ыг багасгах вэ?

1. Халотан
2. Диазепам
3. Кетамин
4. Тиопентал
5. Маннитол

/454./ Метопролол:

1. β_1 селектив адренагонист
2. Изопротеренолын судас өргөсгөх үйлдлийг бууруулна
3. Изопротеренолын хронотроп үйлдлийг бууруулна
4. Изопротеренолын инотроп синергизм үйлдэлтэй
5. Альфа адреноблокатор

/455./ Жирийн жирэмслэлтийн үед өсдөг үзүүлэлт:

1. Минутын эзлэхүүн
2. Амьсгалын (tidal) эзлэхүүн
3. Амьсгалын тоо
4. Вентиляц зөвхөн төрөх үед ихэснэ
5. Амьсгалын үхмэл зай ихэснэ

/456./ Анатомын үхмэл зай:

1. Уушгины хэмжээнээс хамаарна
2. 1мл/кг (биеийн жин) орчим байдаг
3. Мэдээгүйжүүлгийн хэрэглэлээс хамаарч өөрчлөгдөнө
4. Том хүнээс нярайд ач холбогдол багатай
5. Хүүхдийн энэ зай харьцангуй их

/457./ Маннитол:

1. Түүдгэнцэрт шүүгдэнэ
2. Осмосын диуретик
3. Судсан доторх эзлэхүүнийг түргэн ихэсгэнэ
4. Зогсонги дутлын үед үр дүн багатай
5. Тархины хаванд хэрэглэхгүй

/458./ Зузааралт бөглөрөлт кардиомиопати нь:

1. Миокардын анхдагч өвчний нэг хэлбэр
2. Инотроп эмээр эмчлэгдэнэ
3. β -адрен хориглогч (blocking) эмээр засардаг
4. Эмийн эмчилгээнд их мэдрэг
5. Хронотропт мэдрэг бага

/459./ Тиопенталын фармакологийн хувьд үнэн нь:

1. Индукцийн дараа түргэн сэрэх нь элгээр маш түргэн ялгарч буй нь илрэл
2. Индукц хийхэд төвөнхийн рефлексийг сайн намтгана
3. Тиопенталыг зүрх зогссоны дараа тархи хамгаалах зорилгоор хэрэглэдэг
4. Тиопентал гипотензи үүсгэж болно
5. Амьсгал дарангуйлах үйлдэл багатай

/460./ Уушгины судасны гипоксит нарийсал (HPV):

1. 1Цулцангийн O₂-өөр нөлөөлөгдөж
2. Хэсгийн (уушгины) шалчийлтаас судас дарагдах анхдагчаар үүсэх
3. Мэдрэл нь таслагдсан уушгид үүснэ
4. Голдуу уушгины вен нарийсна
5. Пневмоторакс

/461./ Хүнд хэлбэрийн үжлийн эмчилгээнд:

1. Идэвхжүүлсэн С-уураг хийх
2. Цусны чихрийг зохицуулах
3. Эрт үед нь шингэн сэлбэх
4. Гидрокортизон
5. Цаг алдахгүй антибиотик эмчилгээ эхлэх

/462./ Умай урагдлын урьдчилсан нөхцөл:

1. Олон удаа төрсөн
2. Урд умайд хагалгаа хийсэн

3. Олон урагтай
4. Умай дотор ажилбар удаан хийсэн
5. Эхийн нас

/463./ Даралт дэмжлэгтэй (pressure support) вентиляц нь:

1. Даралт хязгаартай-хугацааны циклтэй вентиляц юм
2. Урьдчилан тогтоосон даралтад хүрмэгц амьсгал оруулалт зогсдог
3. Туслах (assist) хэлбэрийн амьсгалаас илүү амьсгалын ачааллыг нэмэгдүүлнэ
4. Өвчтөний уушги тэлэлтээс шалтгаалах амьсгалын эзлэхүүн өгдөг
5. Эзэлхүүн хамааралгүй зөвхөн даралтаар амьсгал өгнө

/464./ Опиоид эм судсанд хийхтэй харьцуулбал нугасанд хийх нь:

1. Шээс түдэх нь их
2. Ижил тун нь илүү хүчтэй нөлөөлнө
3. Хожуу амьсгалын дарангуйлал гардаг
4. Арьс хааяа загатнана
5. Даралт бууруулах нь бага

/465./ Нээлттэй (эргүүлж үл амьсгалах) системд:

1. Чийглэгч боломжийн сайн
2. Амьсгалаар орж буй хийн хүчдэлийг тогтмол байлгаж болдог
3. Зөвхөн хүчилтөрөгч нэмж оруулахад солилцооны шаардлагыг хангана
4. Хийн урсгал өөрлөгдөхөд амьсгалаар орж буй хийн өтгөрөл түргэн өөрчлөгддөг
5. Хуурайшилт бага

/466./ Нярайн уушгины судасны эсэргүүцэл багасдаг шалтгаан:

1. Артерийн цорго битүүрснээс
2. Уушги тэлэгдсэнээс
3. рН буурснаас
4. Хүчилтөрөгчжилт сайжирснаас
5. Алкалоз

/467./ Дорх эмүүдээс сүрьеэгийн эмчилгээний бүрэлдэхүүнд ордог нь:

1. Рифампин
2. Пириметамин
3. Стрептомицин
4. Тетрациклин
5. Ванкомицин

/468./ Премедикацад амьсгал дарангуйлах эм аль болохоор хэрэглэхгүй байх нь:

1. Бага хүүхдэд
2. ГДД ихтэй хүнд
3. Комад байгаа өвчтөнд
4. Маш их айж түгшсэн хүнд
5. Сэтгэцийн өвчтэй

/469./ Вазопрессин:

1. Шээсний урсгал багасгана
2. Цуглуулах сувагт ус нэвчилт ихэсгэнэ
3. Өнчин тархины ар хэсгээс ялгарна
4. Нефроны бүх системд үйлчилнэ
5. Системийн даралтад нөлөөлөхгүй

/470./ Зүүн, баруун титмийн артериуд нь:

1. Эдгээр нь хэлбэр, хангах хэсгээрээ ялгарахгүй
2. Баруун артер баруун ховдлыг тэжээнэ
3. Хоёулаа баруун ховдолд цутгаж орно
4. Зүүн нь зүүн уруудах ба тойрох артер болж салдаг
5. Зүрхийг бүхэлд нь тэжээнэ

/471./ Артерийн даралт ихэсдэггүй өвчтөн аортын гулгиа (regurgitation)-тай бол ямар эмэнд сайжрах вэ?

1. Норэпинефрин
2. Атропин
3. Фенилэфрин

4. Нитропруссид натри
 5. Норадреналин
- /472./ Мэдээгүйжүүлгийн үед гиперкарби үүсгэх шалтгаан:
1. Үхмэл зайн вентиляц ихсэх
 2. Натрийн шохой ажиллахгүй болох
 3. Уушгины эмболизм
 4. Гиповентиляцтай байх
 5. Дурангийн хагалгаа
- /473./ Дорх бодисоос катехол-О-метилтрансферазаар задардаггүйг нь заа:
1. Амфетамин
 2. Изопротеренол
 3. Эфедрин
 4. Допамин
 5. Адреналин
- /474./ Нүд зүрхний (oculocardiac) рефлексээс сэргийлэх арга:
1. Хагалгааны өмнө атропин хийх
 2. Алимь арын (retrobulbar) хориг
 3. Ажилбарын явцад судсаар атропин хийх
 4. Векурониум хийх
 5. Неостигмин хийх
- /475./ L3 - L4 түвшинд бүсэлхийн хатгалт (голын хүрцээр) хийхэд зүү ямар бүтцийг нэвтрэн ордог вэ?
1. Нурууны сэртэнгийн арын холбоос
 2. Сэртэн хоорондын холбоос
 3. Шар холбоос
 4. Өмнөд холбоос
 5. Урт дагуу холбоос
- /476./ Дараах эмгэгээс солилцооны ацидоз болгох нь:
1. Бөөрний архаг дутал
 2. Нойр-дээрх гэдэсний цоорхой (фистул)
 3. Их суулгалт
 4. Элэгний архаг дутал
 5. Гипогликеми
- /477./ АЦДХ (ARDS) оноштой өвчтөний туслах эмчилгээнд орох:
1. Судсанд кортикостероид хийх
 2. Амьсгалын бага эзлэхүүн (6мл/кг) өгөх
 3. Антибиотикийн сэргийлэлт
 4. Цулцан шалчийхгүй, хэт тэлүүлэхгүйгээр PEEP өгөх
 5. Шээс хөөх
- /478./ Капнометр юуг хэмжиж илрүүлэх вэ?
1. Нээлттэй хий зайлуулах системийн гажиг
 2. Шингээгчээс гарч буй нүүрсхүчлийн хий
 3. Ханын (гадны) хүчилтөрөгч хангалт тасрах
 4. Нэмэгдэл, механик үхмэл зай
 5. Хүрээний битүүмж алдагдах
- /479./ Шинэ төрсөн нярайд байж болохгүй нь
1. Амьсгалын ацидозтой
 2. рСО₂ ихтэй
 3. Гипокситай
 4. Гиперокси
 5. Солилцооны ацидозтой
- /480./ Амбулаторийн мэдээгүйжүүлэг:
1. Хагалгааны дараа наад зах нь 2 цаг ажиглах
 2. Хүүхдэд интубац хийхгүй
 3. Круп үүсч бачуурвал
 4. Хагалгааны дараа 6 цаг дотор юм ууж идүүлж болохгүй (NPO) эмнэлэгт хэвтүүлнэ

5. Наркозын аппарат шаардлагагүй

/481./ Мэдээгүйжүүлгийн явцад гипоксеми үүсэх шалтгаан:

1. Цус алдалт
2. Миокардын үйл сулрах
3. Шунт үүсэх
4. Амьсгалын зам бөглөрөх
5. Интубаци нугаларах

/482./ 74 настай тамхи татдаг хүний уушгины зүүн дээд том хийт цэврүү (bullae) авахаар төлөвлөсөн. Хагалгааны өмнөх үзлэгээр юу илэрч болох вэ?

1. Үлдэгдэл эзлэхүүн ихсэх
2. Артерийн CO₂ бага
3. Нэвчилтийн багтаамж (DICO) буурах
4. Амьсгалын шүлтшил
5. Цээжинд эмгэг илрэх

/483./ Гипертироизмтай тироидэктоми хийлгэх өвчтөн:

1. Цулцангийн минимал өтгөрөл (MAC) их байна
2. Хагалгаанаас өмнө 1-2 доло хоног йодот эм өгнө
3. Хагалгаанаас өмнө гүн тайвшруулалт (седац) хийнэ
4. Судсаар пропранолол хийх шаардлага гарч болно
5. Судсаар калийн бэлдмэл хийх нь аюултай

/484./ Эпидурал мэдээгүйжүүлэг нь нугасныхтай харьцуулахад:

1. Удирдахад амаргүй
2. Гипотензи болох нь илүү
3. Нугасны толгой өвдөлт илүү тохиолдоно
4. Арахноидит болох эрсдэл багатай
5. Менингит болох эрсдэлтэй

/485./ Тиопентал цусны даралт бууруулдаг нь:

1. Венийн буцалтыг багасгадаг
2. Захын симпатик мэдрэлийн систем дарангуйлдаг
3. Уртавтар тархины судас хөдөлгөх төвийг саатуулдаг
4. Зүрхний цохилт цөөрүүлдэг
5. Бичил цусны эргэлт багасдаг

/486./ Аорт дотор сөрөг лугшилт хийж зүрхийг дэмжихэд хамаарахгүй нь:

1. Аортын хавхлага бүтэн сайн байх
2. Диастолын үед аорт доторх даралтыг нэмэгдүүлнэ
3. Зүүн ховдлын хожим ачааллыг бууруулна
4. Систолын үед аорт доторх даралтыг бууруулна
5. Митрал гулгиа(regurgitation)-тай үед тустай

/487./ Зүрх-амьсгалын амилуулалт амжилттай болсны дараа ховдлын жирвэлзэл дахихад хийх эмчилгээ:

1. Вазопрессин
2. Хоёр фазат дефибрилляц
3. Амiodарон
4. Эпинефрин их (0.1 мг/кг) тунгаар хийх
5. Магни сульфат

/488./ Гипотермийн үед:

1. Тархины метаболизм буурна
2. Тархины судасны эсэргүүцэл ихэснэ
3. Тархины судасны систем CO₂-т мэдрэг хэвээр байна
4. Тархины солилцоонд илүү их глюкоз шаардлагатай болно
5. Тархины судасны тонус буурна

/489./ Хүүхдийн амьсгалын зам нь том хүнтэй харьцуулахад:

1. Төвөнх харьцангуй дээр
2. Амьсгалын хамгийн нарийн хэсэг төвөнхөөс доор
3. Цээж тэлэх чадвар муу
4. Амьсгалын замын эсэргүүцэл бага

5. Хавирга хэвтээ байрлалтай

/490./ Амниодарон нь:

1. Синус тосгуурын (SA) зангилааны дарангуйлал
2. Тосгуурын жирвэлзлийн үед ховдлын агшилт цөөрүүлнэ
3. Олон хэлбэрт ховдлын тахикардийг аажуусгана
4. Судас нарийсгана
5. Даралт бууруулна

/491./ Агаарын эмболизм тодорхойлохоор доплер хэрэглэх:

1. 0.5мл агаар илрүүлж чадна
2. 15 герц (Hz)-ээр ажиллана
3. Зүрхний баруун тал дээр байрлуулна
4. Капнографи хийснээс мэдрэг нь муу
5. Тодосгогч ашиглана

/492./ Мэдээгүйжүүлгийн 3-р түвшний шинж:

1. Аажим, жигд бус амьсгалах
2. Гипотензи
3. Зовхины идэвхтэй рефлексгүй
4. Нүд хөдөлгөөнгүй, харц төвлөрсөн
5. Брадикарди

/493./ Нүүрсний исэл (CO):

1. Гемоглобинтой хүчилтөрөгчөөс илүү нэгдэх чадвартай
2. FiO2 их байвал хордуулах нөлөө үзүүлэхгүй
3. Эдэд хүчилтөрөгч гемоглобиноос салж орох үйлдлийг багасгана
4. Гемоглобинтай нэгдэх ба салах нь хүчилтөрөгчтэй адил
5. Гемоглобины зөөвөрлөлтөөс шууд хамаарна

/494./ 2 настай хүүхдэд тохирох эндотрахеал гуурсны дотор голч:

1. 3мм
2. 3.5мм
3. 5.5мм
4. 4.5мм
5. 6.5мм

/495./ Хэсгийн мэдээгүйжүүлгийн бодисын үйлдлийн үргэлжлэх хугацаа уртсах нь:

1. Судас нарийсгагч нэмэх
2. Бикарбонат нэмэх
3. Тунгийн хэмжээг ихэсгэх
4. Нүүрстөрөгчжүүлсэн уусмал хэрэглэх
5. Шингэлэхгүй тарих

/496./ Хүүхдийн ларинготрахеобронхитын шинж:

1. Зовиур аажим даамжирч нэмэгдэнэ
2. Хуцуулах маягийн ханиалга
3. Бага зэрэг халуурах
4. Залгиураас доогуур бөглөрөх
5. Хоолой сөөнгөтөх

/497./ Хүчилтөрөгчийн харьцаа тогтоох (орчин үеийн) мэдээгүйжүүлгийн аппаратад тусдаа урсгал хэмжигч бүхий гелийн бортого залгаж ажлуулсан үед өвчтөнд хүчилтөрөгч дутах нөхцөл:

1. Гаднаас ирж буй хүчилтөрөгч дуусах (хаагдах)
2. Хүчилтөрөгчийн урсгал хэмжигчээр урсгал алдагдах
3. Гелийн урсгал хэмжигч хэт их хий гаргах
4. Азотын дутуу исэл (N2O)-ийн хэт их урсгал ирэх
5. Нүүрс хүчлийн хий их хэмжээгээр үүсэх

/498./ Жирэмсний аорт-кавал дарагдлын гипотензид нэрмээс болох нь:

1. Тиопентал
2. Эпидурал хориг
3. Халотан
4. Гиперволеми

5. Гипертириоз

/499./ Рентгенээр шинжлэхэд ерөнхий мэдээгүйжүүлэг хийх заалт:

1. Маш бага насны хүүхэд
2. Оюуны хомсдолтой (ойлгоцгүй)
3. Өөрт захирагдахгүй хөдөлгөөнтэй
4. Халуурч буй
5. Таталттай

/500./ Нитроглицериний миокардад нөлөөлдөг нааштай нөлөө:

1. Титэм судасны агчилт(спазм)-ыг бууруулна
2. Өмнөх ачаалал(preload)-ыг ихэсгэнэ
3. Өмнөх ачааллыг бууруулна
4. Хожим ачаалал(afterload)-ыг ихэсгэнэ
5. Хожим ачаалал(afterload)-ыг бууруулна

/501./ Холимог венийн хүчилтөрөгчийн даралт:

1. Эдийн гипоксийг тодорхойлогч болно
2. Хэвдээ 60ммHg
3. Уушгины артерийн сорьцоор үзнэ
4. Биеийн солилцоо ба температураас хамаарахгүй
5. Артерийн цуснаас ялгаа бага

/502./ Гиперальдостеронизмтай өвчтөн:

1. Адренал булчирхайн дотор (тархилаг) хэсгээс даавар их ялгардаг
2. Гипертензитэй байна
3. Ацидоз болно
4. Гипокалеми үүснэ
5. Гиперкальцеми үүснэ

/503./ Яаралтай кесар зүслэгийн үед хийж болох мэдээгүйжүүлэг:

1. Ерөнхий мэдээгүйжүүлэг
2. Хэсгийн нэвчүүлэх мэдээгүйжүүлэг
3. Субарахноид хориг
4. Эпидурал хориг (эпидурал гуурс урд нь тавиагүй байсан бол)
5. Нейролепт мэдээгүйжүүлэг

/504./ Эпидурал зайд фентанил хийснийг морфин хийсэнтэй харьцуулбал:

1. Хэсгийн мэдээгүйжүүлгийн хүчийг нэмэгдүүлэхгүй
2. Хожуу хугацаанд амьсгал дарангуйлах осол бага
3. Морфинаас тосонд уусах чанар нь бага
4. Үйлчилгээ нь түргэн эхэлдэг
5. Хүндрэл ихтэй

/505./ Допамины ямар тун бөөрний цусны урсгалыг нэмэгдүүлэх вэ?

1. 20-40 мкг/кг/мин
2. 3-10мкг/кг/мин
3. 10-20мкг/кг/мин
4. 0.5-3 мкг/кг/мин
5. 50мкг/кг/мин-аас их

/506./ Шахсан пневмоторакс:

1. Эерэг даралттай вентиляцаас үүсч болно
2. Пневмоторакс жиижг байвал дахин, дахин зураг авч болно
3. Гипотензи үүсгэж болно
4. Плеврийн доторх даралт атмосферийн даралтаас бага байхад үүсч болно
5. Биеийн байдал хөнгөн байдаг

/507./ Мэдрэлийн мэс засалд халотан хэрэглэхэд:

1. Тархины судасны чалх (тонус) нэмэгдүүлнэ
2. Судас өргөсгөнө
3. Тархины цусны урсгал бууруулна
4. Гипокапни үүсгэх зохиомол амьсгалтай хамт хэрэглэнэ
5. Нүүрсхүчлийн хийн хэмжээ ихэснэ

/508./ Сукцинилхолин давтан хийхэд хамгийн олон гардаг хэм алдалт:

1. Синусийн зогсолт
2. Синусийн тахикарди
3. Тосгуурын жирвэлзэл
4. Зангилааны (nodul) хэм
5. Бигемени

/509./ Дигоксин:

1. Тосгуур ховдлын дамжилтыг сааруулна
2. Натри-кали аденозин трифосфатаар идэвхжинэ
3. Агшилт сайжруулна
4. Эс доторх кальцын түвшинг бууруулна
5. Эс доторх натрийн түвшинг ихэсгэнэ

/510./ Нитроглицериний авуур (рецептор) нь:

1. Нитропруссидэд эзлэгдэх (өрсөлдөх)
2. Гуаны циклиз
3. Эсийн доторх энзим
4. Эндотел эсэд байрладаг
5. Миофибриллд байрладаг

/511./ Хэвийн төрсөн нярайн үзүүлэлт:

1. Амьсгал 35/мин
2. PO₂ 60ммHg
3. Зүрхний цохилт 120/мин
4. Цусны систолын даралт 50ммHg
5. Амьсгалын шүлтшилт

/512./ РЕЕР өгөхөд хүчилтөрөгчжил нэмэгдэх учир нь:

1. Амьсгалын зам хаагдалтаас сэргийлэх
2. Шалчийсан цулцангуудыг тэнийлгэх
3. Уушгины судасны гаднах шингэний дахин хуваарилагдалд нөлөөлөх
4. Зүрхний түрэлтийг (output) багасгах
5. Амьсгалын багтаамж ихэсдэг

/513./ Staphylococcus aureus-аар шарх халдварлахаас дангаар нь хийж сэргийлж болох антибиотик:

1. Пенициллин G
2. Ванкомицин
3. Ампициллин
4. Цефалотин
5. Меропенем

/514./ Хагалгааны өрөөнд хүүхдийн дулааныг хадгалахад гол хүчин зүйл:

1. Ажилбар эхлэх үеийн биеийн дулаан
2. Тасалгааны дулаан
3. Бүлээцүүлэх хучлага (хөнжил)
4. Бүлээн шингэн сэлбэх
5. Угаах шингэний дулаан

/515./ Эпидурал хөндийд нэг удаа стероид эм хийхэд гарах хүндрэл:

1. Кушингийн синдром
2. Цусны чихэр ихсэх
3. Гипоталамус-өнчин тархи-адренал тэнхлэгт дарангуйлал үүсэх
4. Арахноидит
5. Даралт ихсэх

/516./ Хүүхдийн эпиглотитын голдуу гарах шинж:

1. Шинж, зовиур гэнэт эхлэх
2. Шүлс гоожих
3. Халуурах
4. Баруун талаараа хэвтэх
5. Ханилгах

/517./ Нүүрсхүчлийн хий (CO₂) ба азотын дутуу ислийн молекул жин нь ижил тул:

1. Адил дулаан, даралтын нөхцөлд 1л хийн эзлэхүүн адил

2. Ууршилтын (уурын) даралт нь адил
3. Уламжлалт (ердийн) масс спектрометрийн аргаар ялгаж болохгүй
4. Нэг ижил тохируулагчтай урсгал хэмжигч(флоуметр)-ээр хэмжиж болно
5. Капнометрээр хэмжинэ

/518./ Жирэмсэн үед зүрх судсанд үүсэх өөрчлөлт:

1. Артерийн даралт өөрчлөгддөггүй
2. Төрсний дараа зүрхний түрэлт их болно
3. Жирэмсний анемийн учир улаан цогцсын тоо цөөрнө
4. Төвийн цусны эзлэхүүн ихэснэ
5. Захын судасны эсэргүүцэл ихэснэ

/519./ Их сулдсан хүүхдийн анхны амилуулалтад:

1. Хуурайлж дулаацуулах, ам хамар, залгиураас соруулж цэвэрлэх
2. Хүчилтөрөгч өгөх
3. Хошуувч-уутаар 10-20смH₂O даралтаар амьсгалуулах
4. Зүрх цохилт 100/мин-аас бага байвал цээж шахах
5. Зүрх цохилт 60/мин-аас бага байвал эпинефрин хийнэ

/520./ Аортокавал дарагдал бууруулах зөв арга:

1. Гараар умайг зүүн тийш нь хэлбийлгэх
2. Эхийн биеийн зүүн талд ивүүр хийх
3. Эхийн биеийн баруун талд ивүүр хийх
4. Эхийг Трендленбургийн байрлалд оруулах
5. Цээж өндөрлөх

/521./ Жирэмсний аорт-кавал дарагдлын гипотензид нэрмээс болох нь:

1. Тиопентал
2. Эпидурал хориг
3. Халотан
4. Гиперволеми
5. Жирэмсний хугацаа

/522./ Ренин-ангиотензиний системтэй харилцан үйлчилж цусны даралт бууруулдаг эм:

1. Лазартан
2. Празозин
3. Эналаприл
4. Меноксидил
5. Нифедипин

/523./ Фентанил их тунгаар (0.1мг/кг) хийхэд:

1. Зүрх цохилт цөөрнө
2. Хүүхэн хараа нарийсна
3. Цагаан хоолойд гуурс тавихад урвал бага гарна
4. Морфин хийснээс (1мг/кг) илүү гүн гипотензи үүсгэнэ
5. Зүрх цохилт олширно

/524./ Ларингоскопи хийх үед ГДД бууруулах бодис:

1. Лидокаин
2. Фентанил
3. Пропофол
4. Сукцинилхолин
5. Дексаметазон

/525./ Нугасны мэдээгүйжүүлгээс даралт буурахад нэмэрлэх хүчин зүйл:

1. Хүйс (жендер)
2. Зүүний үзүүр, огтлол
3. Зүүний хэмжээ
4. Эрт босгох
5. Нас

/526./ Пульсгүй цахилгаан идэвх үүсэх шалтгаанд:

1. Тосгуурын жирвэлзэл
2. Уушгины эмболизм
3. Тосгуурын чичиргээ (Flutter)

4. Шахсан (хүчдэлт) пневмоторакс
5. Ховдлын дамжуулалт алдагдал

/527./ Умайд хүчилтөрөгч илүү хүргэх физиологийн механизм:

1. Минутын вентиляц ихсэх
2. Гемоглобин P50 30ммHg хүрэх
3. Зүрхний цус түрэлт нэмэгдэх
4. Гемокрит нэмэгдэх
5. Амьсгал олшрох

/528./ Зүрх чихэлдлийн (tamponade) шинж:

1. Амьсгаадах, хэвтэхэд дордох
2. Тахикарди
3. Гипотензи
4. Зүрхний авиа чангарах
5. Хөхрөлт үүсэхгүй

/529./ Бензодиазепинуудаас идэвхтэй метаболит өгдөг нь:

1. Лорезепам
2. Мидазолам
3. Оксазепам
4. Диазепам
5. Феназепам

/530./ 3 настай, харьцангуй эрүүл хүүхэд хүйсний ивэрхий засах хагалгаанаас 2 цагийн өмнө 4 унц (1унц=28.3г) алимны шүүс уусан байвал:

1. Хагалгааг хойшлуулна
2. 2 цаг хүлээнэ
3. 4 цаг хүлээнэ
4. Одоо хагалгаанд оруулна
5. 6 цаг хүлээнэ

/531./ Спинал анестези кесар зүслэг хийхэд эпидурал анестезигээс юугаар давуу талтай вэ?

1. Хэсгийн анестетик бага тун орно
2. Мэдээгүйжүүлгийн сегмент тогтоож болдог
3. Анальгези түргэн эхэлдэг
4. Гипотензи болох нь харьцангуй бага
5. Анальгези удаан үргэлжилдэг

/532./ Хүүхдийн бодисын солилцооны идэвх:

1. Том хүнийхээс бага
2. 2 нас хүртлэх үед хамгийн их байна
3. Халуурах өвчний үед буурна
4. Бэлгийн бойжилтын үед өснө
5. Биеийн байдлаас хамаарна

/533./ Хийн нягтрал нь:

1. Хоолойн нарийссан хэсгийн ламинар урсгалд нөлөөлнө
2. Температураас үл хамаарна
3. Тэсрэх чадвартай хамааралтай
4. Турбулент урсгал болон хувирахад чухал нөлөөтэй
5. Ламинар урсгал болон хувирахад чухал нөлөөгүй

/534./ Барбитуратууд:

1. Солилцооны хэмжээ ба тархины цусны урсгалыг хамааралгүй болгоно
2. Хүрэлцээтэй тун хийхэд ЭЭГ изоэлектрик байдалд орно
3. Гипервентиляцын нөлөөгөөр тархины цусны урсгал буурахаас сэргийлнэ
4. Тархины хэвийн энерг зарцуулалтыг хадгална
5. Гиперкапнид тэсвэртэй байлгана

/535./ Яаралтай амилуулах үед судсанд зүү (гуурс) тавиагүй байвал цагаан хоолойд хийж болох эм:

1. Атропин
2. Лидокаин
3. Эпинефрин

4. Хлорид кальц
5. Содын уусмал

/536./ Эпинефрин (5мкг/мл) нэмэхэд ямар бодисын эхийн цусанд эпидурал хоригоос орох хэмжээг 30-50% бууруулдаг вэ?

1. Лидокаин
2. Этидокаин
3. Мепивакаин
4. Бупивакаин
5. Тетракаин

/537./ Жирэмсэн үед зүрх судсанд үүсэх өөрчлөлт:

1. Артерийн даралт өөрчлөгддөггүй
2. Төрсний дараа зүрхний түрэлт их болно
3. Жирэмсний анемийн учир улаан цогцсын тоо цөөрнө
4. Төвийн цусны эзлэхүүн ихэснэ
5. Зүрхний цохилтын тоо цөөрнө

/538./ Норэпинефрин нийлэгжихэд оролцох шаардагдах энзим:

1. Допамин β-гидроксилаз
2. Катехол-О-метилтрансфераз
3. Тирозингидроксилаз
4. Фенилэтанолламин-N-метилтрансфераз
5. Коэнзим А

/539./ Мэдрэлийн мэс заслын өвчтөнд дексаметазон хийхэд:

1. Осмоляр чанараараа үйлдэл үзүүлнэ
2. Тархины хавдрын үүсэлтэй хаванг бууруулна
3. Зөвхөн Аддисоны өвчний үед л хийнэ
4. Гэмтлийн шалтгаантай хавангийн үед үр дүн бага
5. Онкотик даралтыг нэмэгдүүлнэ

/540./ Хагалгааны дараа гипотерми болоход:

1. Хүчилтөрөгч шингээлт ихэсгэнэ
2. Сэрэлт удааширна
3. Захын судасны эсэргүүцэл ихсэнэ
4. Том хүнд чичрэлтгүй дулаан үүсэлт эхлүүлнэ
5. Цусны бүлэгнэлтэд нөлөөлөхгүй

/541./ Хүчилтөрөгч үлээх (их өгөх) хавхлага:

1. Уушгид даралтын гэмтэл учруулж болно
2. Шахсан хийн бортгод байгаа даралтаар амьсгалын системд хүчилтөрөгч өгнө
3. Эерэг даралттай амьсгалуулалтын амьсгал оруулах фазын үед дарж болохгүй
4. Нээлттэй ууршуулагчаар их хийн урсгал үүсч болно
5. Илүүдэл хий гадагшлах

/542./ Яаралтай кесар зүслэгийн үед хийж болох мэдээгүйжүүлэг:

1. Ерөнхий мэдээгүйжүүлэг
2. Хэсгийн нэвчүүлэх мэдээгүйжүүлэг
3. Субарахноид хориг
4. Эпидурал хориг (эпидурал гуурс урд нь тавиагүй байсан бол)
5. Мэдээгүйжүүлгийг хойшлуулах

/543./ Зүрхний гажгуудаас хөхрөлтэй (хөх) хэлбэрт ордог нь:

1. Фалло-гийн дөрвөл
2. Уушгины вен цутгалын бүрэн аномали
3. Том судсуудын байршил солигдсон
4. Ховдлын таславчийн цоорхой
5. Тосгуурын таславчийн цоорхой

/544./ Триамтрен:

1. Кали алдахаас сэргийлэхээр бусад диуретиктэй хамт хэрэглэдэг
2. Альдостероны өрсөлдөх антагонист
3. Шууд алсын сувганцарт үйлчилнэ
4. Анхдагч альдостеронизм (Гонн синдром)-ын үед үр дүн багатай

5. Бөөрний дутагдлын үед голчлон хэрэглэнэ

/545./ Магнези сульфат:

1. Булчингийн мембраны сэрэлтийг бууруулна

2. Хөдөлгөөний ацетилхолинд мэдрэгийг бууруулна

3. Туйлшрал алдуулах ба туйлшрал үл алдуулах булчин сулруулагчдын хоригийн хүчийг ихэсгэнэ

4. Судас өргөсгөх зөөлөн үйлдэлтэй

5. Системийн даралт бууруулах талтай

/546./ Гиперкалемийн ЗЦБ-т илрэх илрэл:

1. Шовх хэлбэртэй Т шүд

2. PR зай уртсах

3. QRS бүрдэл өргөсөх

4. U шүдний далайц ихсэх

5. U шүдний далайц багасах

/547./ Архаг өвдөлт эмчлэхэд хэрэглэдэг эм:

1. Стероид бус үрэвслийн эсрэг эм

2. Таталт дарах (anticonvulsants) эм

3. Гурван цагирагт антидепрессант

4. Опиоид

5. Парацетамол